



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.05.14 №19 (10696)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА ТӨМӨР ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЯВЦТАЙ ТАНИЛЦЛАА

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга өнгөрсөн амралтын өдрүүдэд Дорноговь, Өмнөговь аймагт ажиллаж, Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн 414,6 километр, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 240 километр төмөр замын трассын дагуух бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцлаа. Дэлхий дахиныг хамарсан коронавируст цар тахлын улмаас Монгол Улс хилээ хаагаад гурван сар болж буй хэдий ч төмөр замын бүтээн байгуулалтын ажил эрчимтэй өрнөж байна. Төмөр замын бүтээн байгуулалтыг дотоодын боловсон хүчин, үйлдвэрлэл, нөөц бололцоонд түшиглэн явуулж буй учраас ажил саадгүй үргэлжилж байгаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийг Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, УИХ-ын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн, Зэвсэгт хүчний



Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг болон бусад албаны хүмүүс дагалдан ажиллав. Зүүнбаян-Тавантолгой чиглэлийн

төмөр замын доод бүтцийн буюу далангийн ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб, дотоодын аж ахуйн нэгжүүд хамтран гүйцэтгэж байгаа

бөгөөд газар шорооны ажлын 60 гаруй хувийг хийж дуусгажээ.

Мөн өнгөрсөн хугацаанд хиймэл байгууламжийн буюу гүүр, хоолой, гарам зэргийн ажилд шаардагдах бетон зуурмагийг үйлдвэрлэх найман үйлдвэр, дээд бүтцийн чулуу бутлуурын таван үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна. Ингэснээр төмөр замын барилгын ажилд шаардагдах бетон зуурмаг, балластыг дотоодоосоо бүрэн хангах боломжтой болсон аж.

Зэвсэгт хүчний Жанжин штабын бие бүрэлдэхүүн мөн төмөр зам дагуух өртөө, зөрлөгийн ажлыг хариуцаж, эхнээс нь ашиглалтад оруулж эхэллээ. Зөрлөгийн болон ажилчдын орон сууцыг дэд бүтцийн холболттой барьж байгуулсан нь дараа, дараагийн өртөө, зөрлөгийн жишгийг тогтоож өгсөн байна.

Харин Зүүнбаян-Тавантолгой

чиглэлийн төмөр замын дээд бүтцийн ажлыг "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн ажилтнууд гүйцэтгэж байна.


Өнөөдрийн байдлаар Зүүнбаян өртөөнөөс эхлэн 22,5 километр рейльс төмөр угсарч, үргэлжлүүлэн угсрахад шаардагдах бетон дэр, ган хийц зэрэг бэлдцүүдээ бэлтгэжээ.

Төмөр замын бүтээн байгуулалтын дээрх төслүүд дээр ажилтан алба хаагчид нийлсэн 6000 орчим хүн ажиллаж байгаа бөгөөд тэдний хоол хүнс, хувцас, хэрэгсэл гээд шаардлагатай бүх зүйлсийг дотоодын аж ахуйн нэгжүүд нийлүүлж байгаа юм. Энэ нь цар тахлын хямралын үед өрхийн орлогын эх үүсвэрийг хадгалж буй сайн жишээ болж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга төмөр замын трассын дагуух бүтээн байгуулалтын ажилтай танилцах үеэрээ туслан гүйцэтгэгчээр оролцож буй аж ахуйн нэгжүүд, Зэвсэгт хүчний ангиудын алба хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндэд нь анхаарах, гүйцэтгэлийн түвшнийг жигдрүүлэх зэрэг асуудалд анхаарч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ёорн Розенбергийг хүлээн авч уулзлаа. Уулзалтээр талууд хоёр орны Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа амжилттай хөгжиж байгааг цохон тэмдэглээд цаашдын чиг хандлагын талаар харилцан санал солилцов.



МОНГОЛ СОНСОГЧИД ОХУ-ЫН ТУСТАЙ ҮҮРГИЙН ОНГОЦООР ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ

Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.Шойгутай цахим уулзалт хийлээ. Энэ үеэр сайд Н.Энхболд коронавирусийн цар тахал дэгдсэнтэй холбогдуулан ОХУ-ын Батлан хамгаалах яамны харьяа цэргийн их, дээд сургуулиудад суралцаж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид, тэдний гэр бүлийнхэн, сонсогчид, энгийн сургуулийн оюутнуудыг тус улсын Зэвсэгт хүчний тусгай үүргийн онгоцоор эх оронд нь авчрах хүсэлтийг тавьжээ. ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.Шойгу энэхүү хүсэлтийг нааштай хүлээн авснаар эхний ээлжинд ОХУ-ын Батлан хамгаалах яамны харьяа цэргийн сургуулиудад суралцдаг монгол сонсогчид эх орондоо тусгай үүргийн онгоцоор ирлээ.



АХМАД ДАЙЧНЫГ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙН МЕДАЛИАР ШАГНАВ



Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, түүхийн ухааны доктор, профессор, ахмад дайчин Эрэнцэнгийн Лувсанбалданг Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн медалиар шагналаа.

Медалийг ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд И.К.Азизов Цэрэг, агаарын цэргийн атташе, хурандаа П.Г.Анисов, Батлан хамгаалах яамны ГХАГ-ын зөвлөх, бэлтгэл хурандаа Г.Лүндэн болон бусад албаны хүмүүсийн хамт гардуулан өгсөн юм. Өдгөө 96 насыг зооглож буй Э.Лувсанбалдан нь Аугаа Эх орны дайны I, II зэргийн одонгоор шагнуулсан цорын ганц монгол хүн юм.

Сонирхуулахад, чекист, тактикийн тагнуулч түүний байгуулсан гавьяа, зүтгэлийн талаар Зөвлөлт Холбоот Улсын хошой баатар, БНМАУ-ын баатар, армийн генерал И.А.Плиев "Квантуны армийн сүйрэл" номдоо дурссан байдаг.

Медаль гардуулсны дараагаар ахмад дайчин Э.Лувсанбалдан Элчин сайд И.К.Азизовт талархал илэрхийлээд өөрийн амьдралын түүхэн замнал болоод Аугаа Эх орны дайны ялалтад монгол морьдын байгуулсан үлэмж гавьяа, гүйцэтгэсэн үүргийн тухай сонирхолтой түүхүүдийг хуучлав.

Элчин сайд И.К.Азизов үүнтэй санал нийлж

байгаагаа илэрхийлэн "Сүүлийн жилүүдэд манай хоёр улсын эрдэмтдийн архиваас гаргасан материалыг үндэслэн дайны талаар хэд хэдэн тоо, баримт дурдсан. Эндээс үзэхэд хамтын ялалтад Монголын ард түмний оруулсан хувь нэмэр асар их гэдгийг тод томруун харж болно" гэв.

Мөн тэрээр "Ахмад дайчин Э.Лувсанбалданг сэргэлэн ухаантай, яриа хөөртэй байгаа нь харахад туйлын баяртай байна. Энэхүү ойн медалийг улс орон даяар хэдэн арван хүнд аль хэдийн гардуулсан. Монгол Улсын ахмад дайчид иймэрхүү ёслолын ажиллагаа хийсний дараагаар баяртай, сэтгэл өндөр байх нь хамгийн чухал. Цаашид ч уг ажлыг үргэлжлүүлэн хийнэ. ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар гаргасан өөр шагнал ч бий. Тухайлбал, Ерөнхийлөгч В.В.Путин зарлиг гаргаж Оросын Холбооны Улсын төрийн дээд шагнал болох Найрамдалын одонгоор "Фронт" хэмээн алдаршсан Цэгмид гуайг шагнасан талаар мэдээллийг бид баяртайгаар хүлээж авсан. Цэгмид гуай бол ОХУ-ын сайн найз, манай хамтын ялалтад асар их хувь нэмэр оруулсан хүн мөн. Монголчууд баруун фронтод фашизмыг ялан дийлэхэд ч, Чөлөөлөх дайны үед Японы милитаризмыг бут цохиход ч асар их хувь нэмэр оруулсан бөгөөд үүгээрээ бахархаж явах учиртай шүү" гэв.

Ахмад дайчин Э.Лувсанбалдан нь дайн дуусахад ахлагч цолтой байсан бөгөөд Хилийн цэргийн албанд ажиллан хурандаа цол хүртэхэд хүнд хэцүү зам туулсан. Түүнээс хойш түүхийн ухааны диссертаци хамгаалж, доктор (Ph.D), профессор болсноос гадна БНМАУ-ын Хилийн цэргийн төв хэвлэлийн ерөнхий эрхлэгчээр ажилласан байна. Дараа нь цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлд гарч Шинжлэх ухааны академийн ажилд шамдсан бөгөөд Аугаа Эх орны дайн болон Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Монголын Ардын Арми, Зэвсэгт хүчний оролцсон бүх байлдаан, ажиллагаануудын талаар хийсэн судалгаан дээрээ үндэслэн ном хэвлүүлж, залуу, хойч үеийнхэнд таниулан сурталчлах, тэдэнд цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсныг дурдах нь зүйн хэрэг юм.

ЯЛАЛТЫН БАЯРЫН ЭРГЭН ТОЙРОНД

Өнгөрөгч долоо хоногийн бямба гаригт Аугаа Эх орны дайны Ялалтын 75 жилийн ой тохиолоо. Коронавирусийн цар тахлын улмаас сур дуулиант энэ баярыг даруухан гэгч нь тэмдэглэн өнгөрүүлсэн. Улаан талбайд болдог жил бүрийн сүрт жагсаал, ойн баярт уригдан ирсэн улс, орнуудын төрийн тэргүүнүүд болон ойр хавийг нь зайгүй шахам бүтээн иргэд, хүүхэд, хөгшид болон энэхүү тэмдэглэлт үйл явдлын жинхэнэ эзэд болох ахмад дайчдын жавхлантай царай болон хөнгөн гунигтай харц гээд энэ л дүр зураг хэдийнээ бидний сэтгэлд хоногшжээ. Харин энэ жил аюулт өвчний дэгдэлт, цаг үеийн нөхцөл байдлаас үүдэн бидний нүд, сэтгэлийг баясгадаг тэр бүхэн хумигдаж, хүн бүхэн цэнхэр дэлгэцийн цаанаас баярлаж суухыг илүүд үзэх болсон нь энэ үед хамгийн зөв шийдэл байсан гэдэгтэй маргах хүн үгүй биз ээ.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ХАНДИВ ӨРГӨВ

Аугаа Эх орны

дайны ялалтын 75 жилийн

ойн өдөр Монгол цэргийн

нэгдсэн холбоо, Армийн

ахмад холбоочдын

нийгэмлэгтэй хамтран

"Таван толгой түлш" ХХК-

ийн Сайжруулсан түлш

боловсруулах үйлдвэрийн

хамт олонд амны хаалт,

бээлийг хандивлалаа. Амны

хаалт, бээлий гардуулахын

зэрэгцээ Монголын ирээдүй

болсон бяцхан иргэд

эрүүл, аюулгүй орчинд аз

жаргалтай амьдарч байгааг

бэлгэдэн Улаанбаатар

хотын тугийг гартаа

барьсан хөл бөмбөг тоглож

байгаа бяцхан хүүгийн

баримлыг тус үйлдвэрийн

хамт олонд гардуулсан

нь сэтгэл хөдөлгөөм агшин

байлаа. Мөн Армийн ахмад холбоочдын нийгэмлэгийн зүгээс "Таван толгой түлш" компанийн шилдэг ажилтнуудад шагнал гардууллаа.

Олон жилийн турш Нийслэлийн иргэдийн эрүүл мэндэд ноцтой хохирол учруулаад байсан утааны түвшнийг бууруулах чиглэлээр Засгийн газраас хийгдэж буй сайжруулсан нүүрсээр гэр хорооллын иргэдийг хангах ажил бодит үр дүнгээ өгч Улаанбаатар хотын утаа 50 орчим хувиар буурсан билээ. Энэ ажлын гол төвд нь өдөр шөнийг умартан ажилласан тус үйлдвэрийн хамт олонд ийнхүү талархал илэрхийлсэн юм.

ТАЛАРХЛЫН ЗАХИДАЛ ИРҮҮЛЖЭЭ

БНӨСУ дахь НҮБ-ын ажиллагааг хариуцсан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч Дэйвид Шээрэрээс БНӨСУ-д үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын IX ээлжийн цэргийн багийн захирагч, хурандаа Д.Баттүвшинд хаяглан талархлын захидал илгээсэн байна.

Захидалд “Энэхүү завшааныг ашиглан “UNMISS” ажиллагааны мандатад заагдсан энгийн иргэдийг хамгаалах үүргийг амжилттай хэрэгжүүлж, БНӨСУ-д энх тайвныг бэхжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буй танай цэргийн багийн үйл ажиллагааг бахдан сайшааж байгаадаа баяртай байна. Монгол Улсын IX ээлжийн цэргийн баг 2019 оны 9 дүгээр сард томилогдон ирснээс хойш Юнити мужид үүссэн хэд хэдэн хүндрэлтэй цагийн байдлын үед өөрсдийн мэргэжлийн өндөр ур чадвар, тууштай үнэнч байдал, хичээл зүтгэлээ үйл ажиллагаагаараа харуулсан билээ. Танай цэргийн багаас 2020 оны 1 дүгээр сард Мунга боомтод

зохион байгуулсан усны эргүүл, 2020 оны 3 болон 4 дүгээр сард Маяом болон Абиемном сууринд гүйцэтгэсэн цагийн байдлыг тогтворжуулах урт хугацааны эргүүлийн үүргийн талаар энд онцлон дурдахыг хүсэж байна.

Монгол Улсын цэргийн баг Бентью дахь Дотоодын дүрвэгсдийн хуаран, “Эко” тэргүүний бааз, Жамжанг суурин дахь дүрвэгсдийн хуаранд энгийн иргэд, Нэгдсэн Үндэсний Байгууллагын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж байгаа талаар “UNMISS”-ийн удирдлагаас удаа дараа бидэнд мэдэгдэж байсан юм. Түүнчлэн орон нутгийн иргэдэд чиглэсэн иргэн-цэргийн харилцааны болон сайн үйлсийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанууд, тэр дундаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, инженерийн тусалцаа, дэмжлэг үзүүлэх зэрэг Та бүхний зохион байгуулсан олон төрлийн үйл ажиллагаанд талархаж байна. Та бүхний Абиемном суурин дахь хүн эмнэлгийн байрыг иж бүрэн

засварлаж тохижуулсан сэргээн босголтын ажил мөн НҮБ-тай хамтран коронавирусийн тархалтын эсрэг БНӨСУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн бодитой үйл ажиллагаа, хүчин чармайлтыг бид онцгойлон сайшааж байна.

Эцэст нь 2020 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Бентью суурин дахь Дотоодын дүрвэгсдийн хуарангийн “Зэвсэггүй бүс”-д олон улсын хүмүүнлэгийн байгууллагын ажилтныг зэвсэгт этгээдүүд хүч хэрэглэн хулгайлах гэсэн оролдлогыг таслан зогсоосон Монгол Улсын цэргийн багийн зоримог, шийдвэртэй арга хэмжээнд талархлаа илэрхийлж байна.

Ажиллагааны мандатад заагдсан үүргээ үнэнчээр биелүүлж буй Монгол Улсын IX ээлжийн цэргийн багийн нийт бие бүрэлдэхүүнд дахин талархал илэрхийлж, цаашдынх нь ажил үйлст өндөр амжилт хүсье!

Хүндэтгэсэн: БНӨСУ дахь НҮБ-ын ажиллагааг хариуцсан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай төлөөлөгч Дэйвид Шээрэр” гэжээ.

ЯЛАЛТЫН БАЯРЫН ЭРГЭН ТОЙРОНД ...

(Түрүүч нь I нүүрт)



Москва хотын Улаан талбайд болдог цэргийн парад хойшилж, халдвар тархахаас сэргийлэн Ялалтын баярын олон арга хэмжээг телевиз, онлайнгаар олон нийтэд толилуулсан. Тухайлбал, Уламжлалт цэргийн сүрт парадын оронд ОХУ-ын нисэх хүчнээс нийт 75 байлдааны нисэх онгоц, нисдэг тэрэг оролцсон агаарын шоу Улаан талбай дээгүүр болж телевиз болон онлайнгаар үзэгчдэд нэгэн зэрэг шууд хүрсэн.

Мөн Дэлхийн хоёрдугаар дайнд тулалдаж, амь эрсэдсэн хүмүүсийн гэгээн дурсгалд зориулсан “Мөнхийн хороо” жагсаал ч дээрх жишгээр явагдсан. Энэхүү арга хэмжээг тасалдуулахгүйн тулд оролцохыг хүссэн хүмүүс онлайнгаар зургаа тайлбарын хамтаар илгээсэн юм. Нийтдээ хоёр сая гаруй хүмүүс онлайнгаар зургаа илгээснээс гадна иргэд байрныхаа тагтан дээрээс “День Победы” дууг оройн 19.00 цагт зэрэг эгшиглүүлж бид түүхийн хуудаснаа мартагдахааргүй бас нэгэн үйл явдлын гэрч болсон билээ.

Монгол Улс болон ОХУ, хоёр орны ард түмний найрамдалт харилцаа, дайчин нөхөрлөлийн нэгээхэн илрэл нь Аугаа Эх орны дайны ялалт гэдгийг дэлхийн олон оронд ярьж бичсээр өнөөдөртэй золгосон. Тийм ч учраас

ялалтад томоохон хувь нэмрээ оруулсан Монголын ард түмэн ч бас энэ ойг цомхон байдлаар тэмдэглэсэн. Энэ хүрээнд урлаг, уран сайхнаар дамжуулан иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд голлох үүргийг гүйцэтгэдэг ЦДБЭЧ-ын хамт олон эдгээр өдрийг завгүй өнгөрөөлөө. Тэд аль ч цаг үед, хаана ч хүрч үйлчлэх хүндтэй үүргээ цаг ямагт нэр төртэй гүйцэтгэж ирсэн бөгөөд энэ удаад ч уламжлалаа хадгалж, Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ойд зориулсан театрчилсан кино концертыг Батлан хамгаалахын сайдын санаачилга, Улсын онцгой комиссын зөвшөөрөлтэйгөөр онлайн хэлбэрээр хүргэж үзэгч олныхоо сонорыг мялаасан юм. Бидний зүрхэнд тодоор үлдсэн энэхүү тэмдэглэлт ойг ЦДБЭЧ-ын уран бүтээлчид дуу, хөгжим, бүжгээрээ хөглөж чадсан. Тоглолтод “Священная война”, “Прощание славынки”, “Эх дороги”, “Семнадцать мновений месны”, “Моя Москва”, “Журавли”, “Катюша” зэрэг сэтгэлд хоногшсон олон сайхан бүтээл тайзнаа амилж ялалт ямар их үнэ цэн, олон аавын хүүгийн халуун амь, бүлээн цусаар ирсэн гэдгийг жинхэнэ утгаар нь мэдрүүлсэн гэдгийг дуу нэгтэй хэлэх хүн цөөнгүй байна.

АХИН НЭГ ХАНДИВ ...



Коронавирусийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Их уул цэргийн хүрээ” нийгэмд үйлчлэх ТББ-ын зүгээс Цэргийн төв эмнэлгийн эмч, сувиллагч нарын хамгаалалтын хувцас, хэрэглэл авах хөрөнгийн эх үүсвэрт дэмжлэг үзүүлэн мөнгөн хандив өргөлөө. Хандивыг “Их уул цэргийн хүрээ” ТББ-ын Ажлын албаны дарга, бэлтгэл дэд хурандаа Л.Энхбат, аж ахуйн албаны дарга, бэлтгэл хошууч Б.Насанжаргал нарын хүмүүс Цэргийн төв эмнэлгийн штабын дарга, хурандаа Д.Ганболдод хүлээлгэн өгсөн юм.

Дашрамд, “Их уул цэргийн хүрээ” ТББ нь Зэвсэгт хүчний 256 дугаар ангиас бэлтгэл, чөлөөнд гарсан ахмадуудын санаачилгаар 2018 онд байгуулагдсан аж. 2021 онд тус ангийн түүхт 100 жилийн ой тохиох тул “Их уул цэргийн хүрээ” ТББ-ын зүгээс ойг угтсан зарим ажлыг хэрэгжүүлж байгаа юм. Энэ удаад цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Цэргийн төв эмнэлгийн эмч нарынхаа үйл ажиллагааг дэмжих үүднээс бэлтгэл хошууч Б.Насанжаргалын санаачилгаар хандивын аяныг эхлүүлж цугларсан тодорхой хэмжээний мөнгийг ийнхүү хандивласан аж.

ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДРИЙН ХҮРЭЭНД ...

Олон улсын музейн өдрийг анх 1977 онд Москва хотод болсон Олон улсын музейн зөвлөлийн 11 дүгээр ерөнхий бага хурлаар жил бүрийн 5 дугаар сарын 18-ны өдөр тэмдэглэж байхаар тогтжээ.

Монгол Улс тус өдрийг 1998 онд анх тэмдэглэсэн ба 2003 онд Олон улсын музейн зөвлөлийн Монголын Үндэсний хороо байгуулагдсанаас хойш тасралтгүй 17 жил тэмдэглэж байна. Энэ өдрүүдэд бусад улс орнуудын музей бүр тодорхой сэдвийн дор олон нийтэд зориулсан үйл ажиллагааг зохион байгуулдаг. 2020 онд эл өдрийг “Тэгш байдлын төлөө музей: Олон янз байдал ба тэгш хамруулах” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх юм.

Монгол цэргийн музей нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахим болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд музейн үйл ажиллагаа, үзэсгэлэн, үзмэр, эд өлгийг цувралаар сурталчлан таниулж, түүгээр дамжуулан цэргийн түүхийн мэдлэг, мэдээллийг иргэдэд түгээн ажиллаж байна.

Мөн дээрх сэдвийн хүрээнд нийгмийн тэр бүр хүрч үйлчлэх боломж хомс бүлгийн тэр дундаа сонголын бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлээр музейн үзмэр, эд өлөг, цэргийн түүхийг сурталчлах болон хүүхдийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага зэрэг газарт нүүдлийн музейг хүргэж монгол цэргийн түүхээр аялуулахыг зорьж ажиллалаа.

Олон улсын музейн зөвлөл нь тухайн жилийн Олон улсын



музейн өдрийн сэдэвт тохирсон зурагт хуудас гаргадаг бөгөөд энэ удаад “Тэгш байдлын төлөө музей: Олон янз байдал ба тэгш хамруулах” сэдвийн хүрээнд бүтээлчээр хандаж болохуйц зурагт хуудас гарсан бөгөөд Монгол цэргийн музейн уриалгын

самбарт ажилтан албан хаагчдын гэр бүл, үр хүүхдүүд нэгдэж бүтээлээ ирүүллээ. Мөн хүүхдийн сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын хүүхдүүд Монгол цэргийн музейн үйл ажиллагааг дэмжиж бүтээлээ ирүүлсэн юм.

Редакцын шууданд

Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Аугаа Эх орны дайны ялалтын 75 жилийн ойн медалиар тус аймагт оршин суудаг зарим ахмад дайчдыг шагналаа. Тодруулбал, ОХУ-ын Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Д.М.Владимирович тэргүүтэй албаны хүмүүс Завхан аймагт ажиллаж Тосонцэнгэл сумын иргэн З.Магсарсүрэн, Улиастай сумын иргэн Г.Годроог болон Отгон сумын иргэн Б.Дорж, Д.Ширэнэ нарт Ялалтын 75 жилийн ойн медалийг энгэрт нь зүүж өгөв.

Хошууч Г.БАВУУДОРЖ

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Аугаа Эх орны дайны ялалтын түүхт 75 жилийн ойн баярыг тохиолдуулан ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар ахмад дайчин Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэн Г.Чогсомжав, Орхонтуул сумын иргэн Н.Цээрэн нарыг Ялалтын 75 жилийн ойн медалиар шагнасныг тус улсын Ерөнхий консул Зайнутдинов Рислан Амирович гардуулан өглөө. Мөн энэ үеэр ЗДТГ-ын Цэргийн штабын төлөөлөл ахмад дайчдад бэлэг, дурсгалын зүйл гардуулж хүндэтгэл үзүүлэв.

Дэд хурандаа Ч.ДАМДИНСҮРЭН

186 дугаар анги

Дэлхий нийтэд тархаад байгаа коронавирусээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 10-наас 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл “Хайртай бүхнийхээ төлөө амны хаалтаа зүүцгээ” аяныг өрнүүлж байна. Аяны хүрээнд

“Халдварт вирусийн тархалтыг сэтгэл зүйн хувьд даван туулах аргууд” сэдэвт гарын авлага, санамж, зөвлөмжийг бэлтгэн хэвлэж Орхон аймгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн газруудад тараалаа. Албан байгууллага болон иргэд “Хайртай бүхнийхээ төлөө амны хаалтаа зүүцгээ” аяныг уриалгахан хүлээн авлаа.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

011 дүгээр анги

ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон авто болон хуягт техникийн засварын бүлгүүд Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн нэгж техникүүдэд сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ, засварын ажлыг чанартай хийж бэлэн байдлыг хангахад нь бодитой дэмжлэг үзүүлээ.

013 дугаар анги

Ангийн авто, хуягт, зэвсэглэл, холбооны техник хэрэгслийг зуны улирлын ашиглалтад шилжүүлээ. Нээлтийн ажиллагаанд ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, хурандаа О.Заяат, зэвсэглэл, техник хариуцсан орлогч, дэд хурандаа Д.Бямбаа, бэлтгэл хурандаа Х.Өлзийбат нар оролцсон ба техникт засвар, үйлчилгээг чанартай гүйцэтгэж, осол авааргүй, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар үүрэг өгч, бие бүрэлдэхүүнд амжилт хүслээ. Мөн ЗХЖШ-ын Ар талын газар, Эрүүл мэндийн хангалтын хэлтсээс гаргасан хуваарийн дагуу Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар ангийн байрлалд ирж байнгын бие бүрэлдэхүүнд үзлэг явуулж, эрүүл мэндийн зэрэглэл тогтоогоод байна.

Ахмад Б.ОТГОНПҮРЭВ

325 дугаар анги

2019-2020 оны сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалтай хамтран явуулсан команд штабын сургуульд ангийн удирдлага, офицерууд амжилттай оролцлоо. Тус команд штабын сургуулийн үеэр ангийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөө, төсөл, хувилбаруудыг хэлэлцсэн нь онцлог байлаа.

Ахмад Н.МӨНХБААТАР

330 дугаар анги

Бие бялдар, бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх, үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор ангийн аварга шалгаруулах “Төгс цэрэг-2” буухиа тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд долоон салбарын 32 тамирчин авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байрт ахлах ахлагч О.Цогтбаяр, дэд байрт ахлах ахлагч А.Мөнхбаяр нар тус тус шалгарч өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдав.

Ахмад Э.ГАНЦООЖ

337 дугаар анги

Ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс коронавирусийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим ажлыг хэрэгжүүлж байна. Энэ удаад ангийн Эрүүл мэндийн төвд хамгаалалтын хувцас, хэрэгсэл хандивлалаа.

Дэслэгч Д.ЭРДЭНЭСУВД

Зэвсэгт хүчин хэмээх их айлын гол цөм нь цэргийн нэгтгэл, анги байдаг. Тийм ч учраас Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний төв хэвлэл “Соёмбо” сонины редакц дугаар бүртээ Батлан хамгаалах салбарын аль нэг байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн үйл ажиллагааг сурвалжилж уншигчдынхаа сонорыг мялаахыг эрхэм болгодог. Энэ ч үүднээс бид Зэвсэгт хүчний 120 дугаар ангийг зорьсон юм. Тус анги нь анх 1967 онд тухайн үеийн Ардын Армийн командлагчийн тушаалаар “Ардын Армийн танк эсэргүүцэн сөнөөх артиллерийн тусгай дивизион” нэртэйгээр байгуулагдаж байсан бөгөөд өдгөө 53 жилийн ойтойгоо золгож байгаа дайчин алдрын арвин түүхтэй юм.

Цаг үеийн байдлаас шалтгаалан аливаа байгууллагын үйл ажиллагаа хязгаарлагдмал хүрээнд явагдаж байгаа хэдий ч Зэвсэгт хүчний ангийн бүхий л үйл ажиллагаа дүрмээр тогтоосон цаг хугацаанд явагддаг төдийгүй олон хэлбэрийн сургалт, дадлагаас гажиж боломгүй. Үүнийг батлах мэт биднийг очиход ангийн хашааны гадна талд байрлах сургалт, дадлагын хотхонд “Хориглох байрт, артиллерийн тоот, салаа, батареин ажиллагаа” сэдэвт дадлагын хичээл ид явагдаж “Тоот буундаа”, “Тоот буунаас” хэмээх дуу хадаж байлаа. Энэ л тэдний онцлог, энэ л тэдний жинхэнэ нүүр царай юм.

Тус ангийн захирагч, хурандаа Д.Мөнхсайхан нь жагсаалын байлдагчаас ангийн захирагч болтлоо шат дараалан дэвшиж ажилласан офицеруудын нэг. Түүний баримталдаг гол зарчим нь бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэлийг сайжруулах, ур чадварыг нь дээшлүүлэх, хүн нэг бүрийн бэлтгэлийг албан тушаалын үүрэгтэй нь уялдуулан, чадваржуулах, байнгын бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх, хувь хүний хөгжлийг дэмжих, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, нягт хамтран ажиллахад чиглэгддэг нь мэдрэгдсэн. Тэрээр олон зорилго, зорилт тавьсан бөгөөд ангийн захирагчаар ажиллах хугацаанд олонх нь биелсэн нь нүднээ илт.

Түүний хэлснээр, тус анги 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө “Цэргийн захиргааны удирдлагыг тасралтгүй



Хурандаа Д.МӨНХСАЙХАН

хэрэгжүүлж, бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэн бэлэн байдлыг хангах” зорилгыг дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх ажлыг Монгол Улсын хууль, “Цэргийн нийтлэг дүрмүүд”, шинэчлэн батлагдсан “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, “Сургуулийн жилд цэргийн албыг зохион байгуулах тухай” ангийн захирагчийн тушаал, ангийн дотоод журам, бусад хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохион байгуулж, ангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажил, үүргийг эрчимжүүлэн албан тушаалтан бүрийн ажлын хариуцлагыг дээшлүүлж, салаа, салбаруудад болзолт уралдааныг зарлан сар бүр дүгнэн ажиллаж байгаа аж.

Мөн 2019-2020 оны сургуулийн жилд цэргийн сургалт бэлтгэлийг сайжруулахад олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэл хичээлийг үр дүнтэй зохион байгуулахад онцгой анхаарч, тус ангийн захирагч асан, бэлтгэл хурандаа Б.Цагааны дэмжлэгтэйгээр онол, дадлагын сургалтыг явуулснаар тэдний мэргэжил, ур чадвар эрс дээшилжээ. Түүний үр дүнд өнгөрсөн хоёрдугаар сард хээрийн гаралт, полигоны дадлагын шатанд явагдсан батареинуудын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль, дивизионы гал удирдах сургууль, артиллерийн мэргэжлийн офицер, ахлагч нарын шүүлгийн галын үүрэг, байлдааны харвалтуудыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн районд амжилттай зохион байгуулж тус анги “Үрэг гүйцэтгэх чадавхтай” үнэлгээтэй шалгагдсан байна.



АРТИЛЛЕРИЧДЫН АЖИЛ ҮЙЛС ӨӨДРӨГ БАЙНА

Уг хээрийн гаралтаар тийрэлтэт артиллерийн дивизионы буудлагын үед цахим программыг ашиглан хянах байрыг шилжүүлэн буудлага хийсэн нь ололттой тал болжээ. Мөн сургуулийн жилийн төгсөлтийн шалгалтаар бие бүрэлдэхүүн 84 хувьтай “В” дүнтэй шалгагдсан нь ангийн нийт офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын амжилтын нэгээхэн хэсэг нь юм. Одоогийн байдлаар тус ангийн хамт олон Зэвсэгт хүчний Жанжин штабын “Цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн “Бататгах сургалтын төлөвлөгөө”-ний дагуу сургалтын төлөвлөгөөнд тодотгол хийж, штабын бэлтгэл сургалтыг чанаржуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлон ажиллаж байна. Мөн өнгөрөгч 3 дугаар сард явагдсан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалаас нэгтгэл, ангиудын дунд зохион байгуулсан команд штабын сургуульд оролцож үүргээ амжилттай гүйцэтгэсэн цэргийн онцолсон юм.

Тэрчлэн нийт бие бүрэлдэхүүний нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Төв аймгийн Борнуур суманд таван га газарт хүнсний ногоо тариалж байнгын бүрэлдэхүүний цайны газрын жилийн хэрэгцээг хангаад зогсохгүй, илүү гарсан төмс, хүнсний ногоог ажилчдад болон ахмад дайчдадаа хөнгөлөлттэй үнээр өгч тусалдаг гэнэ.

Үнэхээр л энэ бүхэн нь тус ангийн удирдлага, штабын бүрэлдэхүүнээс гадна шат дараалсан дарга нарын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны бодит үр дүн юм.

Ангийн штабын дарга, дэд хурандаа Б.Даваа-Очир 2019-2020



Дэд хурандаа Б.ДАВАА-ОЧИР


оны сургалтын төлөвлөгөөний дагуу хоёрдугаар үеийн эхэнд явагддаг багшлах бүрэлдэхүүний заах арга зүйн цугларалтыг явуулж, цаашид цэргийн сургалт бэлтгэлийг үр дүнтэй зохион байгуулах талаар анхаарч ажиллахыг сургалт хариуцсан албан тушаалтнуудад үүрэг өгсөн аж. Мөн ЗХЖШ-аас өгсөн үүргийн дагуу нийт бие бүрэлдэхүүнд “Цэргийн нийтлэг дүрмүүд”, шинэчлэн батлагдсан “Цэргийн албыг зохион байгуулах заавар”, “Офицер, ахлагч нарын ёс зүйн дүрэм”-ийг сайтар судлуулсан ба албан тушаалтан бүрээс шалгалт авах ажлыг зохион байгуулжээ. Түүний зэрэгцээ цэргийн зэвсэглэлийн шинэчлэлд өөрчлөлт хийхээр Тийрэлтэт артиллерийн байлдааны машиныг сайжруулах,

зөөврийн харвах суурийг автомашин дээр суурилуулах, Хөдөлгөөнт хянах байрыг боловсронгуй болгох төслийн ажил, тийрэлтэт артиллерийн дивизионы дадлагын хотхоныг байгуулж байгаа зэрэг нь тус ангийн хамт олны хийж гүйцэтгэж байгаа чухал ажлуудын нэг гэдгийг тодотгосон.

Тус ангид бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ, нөхөн сэргээх, ойжуулах гээд олон ажил эрчимтэй явагддаг. Тухайлбал, артиллерийн дивизионы таван танхимд бичгийн болон сурагч ширээ, сандлын хүрэлцээ хангалтгүй байсан бөгөөд салааны захирагч нар өөрсдийн болон ангийн дотоод нөөц бололцоог ашиглан тус тусын хичээлийн танхимыг засварлаж, ширээний тавцанг солих, хуучин ширээг засварлах ажилд идэвх санаачилгатай байж сургалт явуулах ая тухтай орчныг бүрдүүлжээ. Үүнтэй нэгэн адил ангийн доторх ногоон байгууламжийг цэцэгжүүлэх үүднээс “Туул тосгон”-ы 12 дугаар хороонд байрлах Мод үржүүлгийн газартай хамтран ажиллаж ангийн байрлалд 400 гаруй модны суулгацыг тарьж ургуулсан бөгөөд эдгээр нь тус ангийн гар нийлж, сэтгэл шингэсэн хамт олны бас нэгэн онцлох ажил юм.

Сүүлийн үед эрчимтэй арга хэмжээ авч, бодит ажил болгож байгаа биеийн жингийн индекс тус ангид тун сайн мөрдөгдөж байгаа гэж хэлж болно. Тухайлбал, байнгын бүрэлдэхүүний биеийн жин, өндрийн зохистой харьцаа, биеийн жингийн индекс, стандартыг тодорхойлж, судалгаа хийн, шаардлага хангаагүй цэргийн алба хаагчидтай тусгай хөтөлбөрийн дагуу нэмэлт сургалтыг явуулснаар бие бүрэлдэхүүний 90 хувь нь биеийн жингийн зохистой харьцааг бүрдүүлсэн нь давуу тал бөгөөд бусад ангиудад ч үлгэр жишээ болохуйц юм. Түүнчлэн тус ангийн тогтмол гэж хэлж болох нэг ажил нь офицер, ахлагч, ажилтан алба хаагчдыг Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт жилд хоёр удаа хамруулж хэвшсэн нь ажилтнаа бодсон ажлын нэг ажээ.

Тус ангид эрхэлсэн ажилдаа эзэн нь болж бусдадаа үлгэр дуурайл үзүүлж, албандаа чин сэтгэлээсээ ханддаг цэргийн алба хаагчид олон. Тухайлбал, дэслэгч Г.Маналжав. Тэрээр цэргийн хүн, цэргийн эмч болоод удаагүй байгаа хэдий ч албандаа дадсан нэгэн. Коронавирусийн цар тахал гарсантай холбоотойгоор түүний ажил нэмэгдэхийн зэрэгцээ албандаа цаашид олон ажлуудыг хэвшүүлэхээр ажиллаж байгаа гэнэ. Халдварт вирус гэдгээ эхэлснээс хойш урьдчилан сэргийлэх



Дэслэгч Г.МАНАЛЖАВ

зорилгоор тэрээр өглөө бүр биеийн халууныг хэмжиж, гар ариутгалыг хийснээр ангийн байрлалд нэвтрүүлэн бүхий л албаны

өрөө, цэргийн байр, хичээлийн танхимуудад урьдчилан сэргийлэх үзүүлэн, мэдээлэл, сурталчилгааны материалыг байршуулсан ба бие бүрэлдэхүүнийхээ эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлж байна. Мөн биднийг тус ангид байх хугацаанд ЗХЖШ-ын даргын тушаалаар шүдний эмч нар тус ангид ажиллаж байсан юм. Эхний ээлжинд Улаанбаатар цэргийн хүрээний хугацаат цэргийн алба хаагчидтай ангиудад ажиллаж байгаа бөгөөд нэг ангид цэргийн тооноос хамаарч 10-20 орчим хоног болдог гэнэ. Энэхүү ажлыг амны хөндийн эрүүл мэндийг сахин хамгаалах чиглэлээр ЗХЖШ-ын Ар талын газрын Эрүүл мэндийн хангалтын хэлтсээс зохион байгуулж буй бөгөөд тус хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч Н.Эрдэнэбаяр, Зэвсэгт хүчний 016 дугаар бригадын шүдний эмч, ахмад Г.Өнөржаргал нар томилогдон үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Цэргийн алба хаагчдад амт чанартай, илчлэг сайтай халуун хоол, цайгаар үйлчлэх хариуцлагатай албыг хашдаг албан тушаалтны нэг нь ахлах тогооч, ахлах ахлагч Ю.Ганчимэг юм. Тэрээр удам дамжсан цэргийн хүн бөгөөд түүний



Ахлах ахлагч Ю.ГАНЧИМЭГ

аав дэд хурандаа асан Юмчин тус ангид алба хааж байсан бөгөөд аавынхаа ажиллаж байсан ангид алба хаах боломж олдсонд ихээхэн бэлгэшээдэг аж. Зэвсэгт хүчинд 17 дах жилдээ алба хааж байгаа тэрээр тус ангид нэг жил болж байгаа юм. Энэ хугацаанд тэрээр манай улсад зохион байгуулагддаг олон улсын болон дотоодын хээрийн сургуулиудад ахлах тогоочоор байнга оролцдог бөгөөд 2019 онд зохион байгуулагдсан “Чингэс хааны цом” олон улсын тогооч нарын төмцээний гурван төрөлд оролцож хоёр төрөлд нь хүрэл медаль хүртэж байсан мэргэшсэн тогооч нарын нэг аж. Эх орноо батлан хамгаалахаар ирсэн олон аавын хөвгүүдэд амт чанартай хоол, цайгаар хангах үүргээ нэр төртэй гүйцэтгэхийн зэрэгцээ сүүлийн үед цэргийн алба хаагчдынхаа дархлааг дэмжих чиглэлээр хоолны орц, чанарт ихээхэн анхаарч ажиллаж байгаа талаар тэр дурдсан.

Мөн тус ангид алба хааж байгаа цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид ангидаа үргэлжлүүлэн хугацаат цэргийн алба хаагчаас цэргийн гэрээт алба хаагч, цэргийн гэрээт алба хаагчаас ахлагч болж энэ л ангидаа, цаашид Зэвсэгт хүчинд хүчин зүтгэх хүсэл тэмүүлэл дүүрэн явдаг цэргийн алба хаагч олон аж. Тэдний нэг бол дэд түрүүч Т.Тэмүүжин юм. 2019 оны хоёрдугаар ээлжээр тус ангид татагдан ирсэн тэрээр өмнө нь ҮБХИС-ийн “Тэмүүжин-Өрлөг” сургуулийг төгссөн бөгөөд цэргийн албанд багаасаа дурласан нэгэн. Тиймдээ ч цэргийн хэргийн



Дэд түрүүч Т.ТЭМҮҮЖИН

эрдмээр бусдыгаа хошуулахын зэрэгцээ удирдан зохион байгуулах тал дээр давуу байж салаа, тасгийн бие бүрэлдэхүүнийг байнга уриалж болох хэтийн зорилго өвөртөлсөн талаар хамт олон нь ам сайтай байсан. Цэргийн алба нэр төртэй хаагаад ҮБХИС-д элсэлт өгч офицер болох хэтийн зорилго өвөртөлсөн гэнэ. Биеэ зөв авч явах, бие даах чадвар, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нөхөрсөг байх гээд мөн ч их зүйл сурсан даа, албаа дуусгаад энд сурсан эрдмийнхээ ид шидийг гаргах юм сан хэмээн ярьсан.

Тус анги цөөн тооны цэргийн гэрээт алба хаагчидтай бөгөөд тэднээс хоёр алба хаагч нь Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж байгаа энхийг дэмжих ажиллагаанд оролцох боллоо хангаад байгаа аж. Үүний нэг нь түрүүч Э.Ванданлхам бөгөөд Өвөрхангай аймгаас 2018 онд хугацаат цэргийн албанд татагдан тус ангид иржээ. Тэрээр хугацаат цэргийн албаа амжилттай хаахаад өдгөө цэргийн гэрээт албанд элсэж



Түрүүч Э.ВАНДАНЛХАМ

өөрийн мэргэжлийн ур чадвараа ахиулж байгаа нь энэ. Мөн л цэргийн албаны амтанд орж, Зэвсэгт хүчинтэй амьдралаа холбохоор эргэлт бүцэлтгүй шийдчихээд байгаа нэгэн. Түрүүч Э.Ванданлхам энхийг дэмжих ажиллагаанд оролцох болсноо ангийн хамт олны минь ач гэж бахархал дүүрэн өгүүлсэн. Үнэндээ тийнхүү бахархам амжилт үзүүлэх болсон нь тус ангийн хамт олны хичээл зүтгэл, захирагч, дарга нарын бэлтгэл сургуулилтын гавьяа хэмээн үнэлэхээс өөр аргагүй. Мөн тэрээр цааш хэлэхдээ энэхүү цэргийн гэрээт алба бидэнд маш олон боломжийг олгож байгаа. Цалин авна, дээр нь ажлын найман цагт ангидаа цагийн хуваарийн дагуу сургалт бэлтгэлдээ хамрагдаад бусад цагт нь байнгын бүрэлдэхүүний нэгэн адил гэр лүүгээ харьдаг. Мөн амралтын өдрийг гэртээ өнгөрүүлдэг гээд олон давуу тал байгаа. Тиймээс залуусаа цэргийн гэрээт албанд ирэхийг уриалж байна гэсэн.

Цэргийн анги гэдэг ийм л их ажил өрнөж олон аавын хүү, ээжийн охидыг эрдэм мэдлэг, амжилт бүтээлийн их үйлсэд урин дуудах бөгөөд бум бужигнаж, түм түжигнэсэн газар. Ийм л их ажил үйлсийн уурхай болсон Зэвсэгт хүчний нэгэн ангийн эгэлхэн бие бүрэлдэхүүний үйл хэрэг улам бүр өөдрөг байхын ерөөл өргөө.



ЦЭРГИЙН ДИПЛОМАТ АЛБАНЫ

МЭНДЧИЛГЭЭ

МАХН-ын Төв хорооны шийдвэрээр 1968 онд БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа Элчин сайдын яаманд анхны цэргийн атташег томилж ажиллуулснаар цэргийн дипломат албаны түүх эхэлсэн юм.

Зэвсэгт хүчний төрөл мэргэжлийн цэргийн өдрийг бий болгон тэмдэглэж тогтсон жишгийн дагуу Батлан хамгаалахын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/121 дүгээр тушаалаар "Цэргийн дипломат албаны өдөр"-ийг бий болгож, энэ жил бид бүхэн тус албаны 52 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж байна.

Түүхт ойн энэ өдөр гадаад улсад цэргийн атташегийн албаны эхний замыг гаргасан цэргийн ахмад дипломатчид, Монгол Улсын батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Онцгой байдал, Цэрэг-техникийн харилцааны асуудлыг эрхлэн идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад дайчид болон үе үеийн цэргийн дипломатчиддаа гүн хүндэтгэлээ илэрхийлж, эрүүл энх, ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэж, сайн сайхны



ерөөлийг өргөн дэвшүүлэе.

Мөн Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарал тавьж, цэргийн дипломат албыг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь идэвхтэй, үр дүнтэй явуулах нөхцөл, боломжоор хангаж, удирдан зохион байгуулж байгаа Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлага, ТЕГ-ын Цэргийн тагнуулын газар, бидний ажилд зөвлөмж, чиглэл өгч, байнгын дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг Гадаад харилцааны яамны чиглэлийн болон гэрээ, эрх зүй, консулын газрууд, тус яамны удирдлагууддаа гүн талархал

илэрхийлэе.

Та бүхэнд Цэргийн дипломат алба байгуулагдсаны 52 жилийн ойн мэндийг дэвшүүлж, ажлын арвин их амжилт, аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөө!

Монгол цэргийн сүлд хийморь бадарч, үйлс нь өөдрөг, өлмий нь бат бай!


БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Э.ГАНСҮХ

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Монгол Улсын Батлан хамгаалах яаманд 1970-аад оны эхээр байгуулагдсан Гадаад харилцааны тасаг 1986 онд Гадаад харилцаа, гэрээ эрхийн хэлтэс болж

оролцох, мэдээлэл солилцох, цэргийн амрагчид харилцан солилцох, соёлын болон спортын арга хэмжээг зохион байгуулах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлдэг.

бусад олон улсын байгууллагатай Батлан хамгаалахын харилцааны асуудлаар жил бүрийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан байна. Манайх дотооддоо олон улсын



Батлан хамгаалах яамны ГХАГ-ын үе үеийн дарга, мэргэжилтнүүд. 2018 оны 5 дугаар сарын 15

улмаар 2009 оноос Гадаад хамтын ажиллагааны газар болон өргөтгөн зохион байгуулагдсан ба салбарын гадаад харилцаа, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг эрхлэн гадаад улсуудын адилтгах нэгжүүд, гадаад улсаас Монгол Улсад болон хавсран суугаа Элчин сайдын яамд, Батлан хамгаалахын атташе нартай харилцаж, Монгол Улсаас гадаад улсуудад суугаа Элчин сайдын яамны цэргийн атташе нарыг удирдлагаар хангаж байна. Энэ нэгжийг бэхжүүлэхэд эхнээс нь удирдан ажиллаж байсан хошууч генерал С.Гангааням, хурандаа О.Сандуйжав, дэд хурандаа Б.Төмөрбат, дараагийн үе үеийн удирдлага болох хошууч генерал Б.Эрдэнэбат, бригадын генерал Ч.Сосорбарам, хурандаа А.Сүхбаатар, Г.Лүндэн, Б.Батзориг,

Бид салбарын гадаад хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэн одоогийн байдлаар дэлхийн 37 улстай цэрэг-техникийн болон цэргийн хамтын ажиллагааг цэрэг-улс төр, аюулгүй байдал, цэрэг-техник болон аж үйлдвэр, цэргийн мэргэжлийн боловсон хүчний сургалт, энхийг сахиулах болон олон улсын терроризмтой тэмцэх, эрдэм шинжилгээ, мэдээлэл-судалгаа, цэргийн ар тал болон спорт, соёл урлагийн чиглэлээр хөгжүүлж байна.

Дээрх орнуудаас ОХУ, БНХАУ, БНТУ, Беларусь, Украин зэрэг таван улстай тусгайлан тохиролцсон эрх зүйн актын хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэлд байгаа зэвсэг, байлдааны техникийг сэргээн засварлах, шинэчлэх, дэвшилтэт зэвсэг, техникийг нэвтрүүлэх зорилтыг эрхэмлэн "цэрэг-техникийн

болон хоёр талын 20 гаруй удаагийн сургууль дадлага, уулзалт, семинар хийж, гадаадын орнуудад болсон адил төрлийн арга хэмжээнд манай 150 гаруй төлөөлөгчид оролцож байна.

Батлан хамгаалах яам нь харилцааны энэ бүх арга хэмжээндийг Гадаад харилцааны яам, бусад холбогдох байгууллагуудтай төрийн бодлогын хэмжээнд харилцан уялдуулж хэрэгжүүлдэг. Бидний харилцааны ажилд зөвлөмж, чиглэл өгч байнгын дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг Гадаад харилцааны яамны чиглэлийн болон гэрээ, эрх зүй, консулын газрууд байдгийг энд онцлон дурдах учиртай.

Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид олон улсын энхийг сахиулах ажиллагаанд амжилттай оролцож 2002 оноос хойш манай 18 мянга гаруй цэргийн алба хаагч Ази, Африкийн 10 гаруй улсад үүрэг гүйцэтгэж, зарим генерал, офицерууд НҮБ-ын энхийг сахиулах хүчний командлалын удирдах албан тушаалд нэр төртэй ажиллаж байна.

Манай Зэвсэгт хүчин Орос, Хятад, Энэтхэг, Америк, Өмнөд Солонгос, Катар зэрэг улстай хоёр болон олон талын хэргийн сургуулийг жил бүр дунджаар манай Зэвсэгт хүчний 300 гаруй алба хаагч 17 орны 60 гаруй сургуульд суралцаж байна. Энэ бүхнийг манай цэргийн гадаад харилцааны ажилтнуудын идэвхтэй ажиллагаа, оролцоотойгоор гүйцэтгэж байгаа бөгөөд цаашид батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаа улам бүр өргөжих хандлагатай байна.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаанд цэрэг, цэргийн дипломат, олон улсын харилцаа, улс төр судлал, гадаад хэл, хэвлэл мэдээллийн зэрэг мэргэжлээр бэлтгэгдсэн хүмүүс ажиллан дипломат болон цэргийн албаны мэргэшсэн бүрэлдэхүүн болж төлөвшсөн бөгөөд тус алба үүсэж бэхжсэнээс хойш 52 жилийн хугацаанд эгнээ нь 100 хол давсан бүрэлдэхүүн, ахмадуудаар тоологдох болж тэднээс улсын дипломат албанд дэвшиж өндөр албан тушаалд очсон нь 4 бий.

МОНГОЛ УЛСААС ГАДААД УЛСАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕ НАР



НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газрын цэргийн зөвлөх, бригадын генерал Б.ДАВААДОРЖ



ОХУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, бригадын генерал Г.ЭНХБААТАР



БНХАУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа Б.ГАНЗОРИГ



АНУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа Г.НАРАНХҮҮ



Бельгийн Хаант Улсад суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа М.БАТЧУЛУУН



ХБНГУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа С.САМДАНГЭЛЭГ



БНСУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, хошууч Э.ТҮШИГ



Япон Улсад суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа Л.ЭНХБАТ



БНТУ-д суугаа Батлан хамгаалахын атташе, хурандаа С.БАТБУЯН

МОНГОЛ УЛСАД СУУГАА ГАДААД ОРНЫ БАТЛАН ХАМГААЛАХЫН АТТАШЕ НАР

Монгол Улсад ОХУ, БНХАУ, АНУ, БНТУ, БНСУ, Япон зэрэг зургаан улсаас батлан хамгаалахын атташе Зэвсэгт хүчнээ төлөөлөн сууж цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

- ОХУ-ын Цэрэг, агаарын цэргийн атташе, хурандаа П.Г.Анисов
- БНХАУ-аас суугаа Батлан хамгаалахын атташе, ахлах хурандаа Бао Юй Хай
- АНУ-аас суугаа Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Филип Лүү
- БНТУ-аас суугаа Цэргийн атташе, хурандаа Тамир Аккан
- Япон Улсаас суугаа Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Хигашия Кейчи
- БНСУ-аас суугаа Батлан хамгаалахын атташе, дэд хурандаа Со Мүн Сог

ЦЭРГИЙН АТТАШЕ НАР

Дипломат албаны тухай хуульд, "Цэргийн атташег холбогдох байгууллагын саналыг үндэслэн Гадаад хэргийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилж байх, цэргийн атташе нь Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрхт дипломат албан тушаалтан байх" аар хуульчилж өгснөөр манай орчин цагийн цэргийн дипломат албаны эрх зүйн үндэс бүрдсэн.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд, гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал юм. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь дэлхийн улсуудтай тэргүүлэх зорилт мөн гэж заасан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд улс төрийн харилцааны бүрэлдэхүүн хэсэг болох цэргийн харилцааг тогтоож хөгжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой. Энэ ч утгаар нь төр, засгаас цэргийн гадаад харилцааг хөгжүүлэхэд зохих ёсоор анхаардаг.

Дэлхийн дахинд их гүрнүүдийн хүчний харьцаа, дэг журам өөрчлөгдөж, Монгол Улсын гадаад орчинд гол нөлөө үзүүлж байсан Орос-Хятадын харилцаанд гарсан өөрчлөлт нь манай улсын аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлыг Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй илүү өргөн хүрээнд авч үзэхийг нөхцөлдүүлсэн.

Түүхт ойн энэ өдөр гадаад улсад цэргийн атташегийн албаны эхний замыг гаргасан цэргийн ахмад дипломатчид БНМАУ-аас ЗСБНХУ-д сууж байсан цэргийн атташе, хошууч генерал Цэрэндашийн Содномдаржаа, Монгол Улсаас НҮБ-ын дэргэдэх Байнгын төлөөлөгчийн газрын анхны Цэргийн зөвлөх асан хошууч генерал Гүрийн Рагчаа, Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайдын яамны цэргийн атташе асан хошууч генерал Михайл Борбаатар нарыг хүндэтгэн дурсаж байна.

Мөн БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны анхны цэргийн атташе, хурандаа Б.Цогтбаатар, Монгол Улсаас Бельгийн Хаант Улсад суугаа Элчин сайдын яамны анхны Батлан хамгаалахын атташе, хурандаа

А.Сүхбаатар, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны анхны цэргийн атташе, дэд хурандаа Д.Эрдэнэбилэг нар болон тэдний албыг залгуулж Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Онцгой байдал, Цэрэг-техникийн харилцааны асуудлыг эрхлэн идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан ахмад дайчин, хошууч генерал Р.Гүнчин-Иш, Г.Дугарсүрэн, Д.Бадам, бригадын генерал М.Хүрлээ, хурандаа Д.Намжил, Б.Батзориг, Т.Баярмагнай, Ш.Жаргалсайхан, Б.Балдан, Гиваа, Ч.Баатар нар юм.

Батлан хамгаалах салбарын түүхэнд эмэгтэй цэргийн алба хаагчид гадаад улсад дипломат албанд зүтгэх зам мөрийг хурандаа Д.Энхтүвшин анхлан нээж, 2014-2017 онд Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны батлан хамгаалахын атташегаар томилогдон үүргээ нэр төртэй биелүүлсэн. Эмэгтэй цэргийн дипломатчид түүчээг залгуулан хурандаа О.Ариунаа Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яамны батлан хамгаалахын атташегаар 2015-2018 онд ажилласан бөгөөд хошууч Б.Ариунаа 2017 оноос Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны Батлан хамгаалахын дэд атташегаар томилогдон ажиллаж буйг онцолъё.

1990-ээд оноос эхлэн цэргийн харилцаандаа АНУ, ХБНГУ, Япон, Франц, БНТУ, БНСУ зэрэг дэлхийн нөлөө бүхий улстай хамтын ажиллагаагаа хөгжүүлэн, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэгз илгээх болсон энэ үеэс монгол төрийн гадаад бодлогод тусгалаа олсон "гуравдагч хөршийн бодлого"-д нийцэж, түүнийг хэрэгжүүлэх алхам болсон. Цэргийн гадаад харилцаа ийнхүү өргөжсөнөөр одоогоор манай орон 22 улстай цэргийн атташе харилцан суулгах хэмжээнд харилцаатай болоод байна.

Батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд манай улсаас гадаад улсад суугаа цэргийн атташегийн алба онцгой дэмжлэг үзүүлэн ажиллаж өнөөгийн байдлаар манай улсаас ОХУ, БНХАУ, АНУ, Бельгийн Хаант Улс, ХБНГУ, БНСУ, БНТУ, Япон зэрэг нийт найман улсад цэргийн атташе, атташегийн алба, НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөх ажиллаж байна. Манай атташе нар Монгол Улсын нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд бусад улсыг хавсран сууж, тэдгээр улстай цэргийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна.



Зүүн гар талаас, дэд хурандаа Ч.Нямсүрэн, хошууч Э.Цэнгүүн, ахмад Б.Мөнхбилэг, хошууч Б.Мөнхбаяр, хурандаа Б.Батбаяр

Н.Нүрээд, Ж.Мэндээ, Б.Энхжаргал, Ч.Ерөөлцэнгэл, Д.Мөнх-Очир, И.Батболд, Д.Ариунболд нарын үүрэг, оролцоо их байсныг хэлэх нь зүйн хэрэг юм.

Салбарын харилцаа, хамтын ажиллагаатай орнуудтай харилцан айлчлалын давтамжийг хадгалах, зөвлөлдөх уулзалт, ажлын хэсгийн хуралдааныг харилцан зохион байгуулах, цэргийн алба хаагчдыг сургууль, дамжаанд суралцуулах, олон улсын болон хоёр талын команд-штабын сургууль дадлага, хэргийн сургууль, зэвсэглэл, техникийн засвар, үйлчилгээ хийлгэх, тусламж авах, олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд

хамтын ажиллагаа"-г хөгжүүлж байгаа юм.

Үүний зэрэгцээ НҮБ, НАТО, Европын холбоо, бусад засгийн газар хоорондын болон олон улсын ажиллагааг хөгжүүлэн ажиллаж байгаа билээ.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар, яам хоорондын 57 гэрээ, хэлэлцээр байгуулсан. Эдгээр гэрээ, хэлэлцээрийн дагуу жилд дунджаар гадаадын 20 гаруй орны цэргийн 50 гаруй төлөөлөгчдийг хүлээн авч, манай салбараас 350 гаруй ажилтан гадаадын 30 гаруй улсад айлчлал, албан томилолтоор явж, 11 улс болон

52 ЖИЛИЙН ОЙ ТОХИОЖ БАЙНА

СҮҮЛИЙН ЖИЛҮҮДИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУДААС ...

Батлан хамгаалах салбарт харилцаа, хамтын ажиллагаатай улс орнуудтай өндөр, дээд түвшний айлчлал, солилцоог идэвхжүүлж, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны хөгжил, цаашдын төлөвийн талаар харилцан санал солилцон, шийдвэр гаргах зорилгоор ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, БНСУ, Япон, Их Британи, Австрали, БНТУ, БНЭУ-тай батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалт, НАТО-тай ажлын хэсгийн уулзалтыг тогтмол зохион байгуулдаг болоод байна. Үүнд:

ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу 2018 оны 10 дугаар сард Батлан хамгаалахын сайд Н.Энхболдын урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр хоёр орны цэргийн хамтын ажиллагааны урт хугацааны хөтөлбөрт гарын үсэг зурсан нь хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцааг идэвхжүүлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн үйлчлэлийг 2024 он дуустал сэргээх тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын протоколд гарын үсэг зурсан нь буцалтгүй тусламж үзүүлэх тухай эрх зүйн үндсийг баталгаажуулав. Хоёр орны дайчин нөхөрлөлийн тэмдэглэлт үйл явдал болсон Халхын голын байлдааны ялалтын ойг талууд хамтран тэмдэглэсээр ирсэн бөгөөд түүхт 80 жилийн ойгоор ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Оросын армийн А.В.Александровын нэрэмжит Дуу, бүжгийн эрдмийн чуулга, ОХУ-ын Агаар-сансрын хүчний уран нислэгийн "Русские витязи" бүлэг Монгол Улсад ирж Халхын голын байлдааны ялалтын ойн арга хэмжээнд оролцсон юм.

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг Олон улсын цэрэг-техникийн форумд Батлан хамгаалахын дэд сайд Т.Дуламдорж оролцож, ОХУ-ын Батлан хамгаалахын дэд сайд А.В.Фоминтой хоёр талын уулзалт хийсэн.

БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Вэй Фөнхөгийн урилгаар Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2018, 2019 онд БНХАУ-д албан ёсны болон ажлын айлчлалыг хийлээ. Айлчлалын үр дүнд БНХАУ-ын Батлан хамгаалах яамнаас Монгол Улсын Батлан хамгаалах яаманд цэргийн буцалтгүй тусламж олгох тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан нь манай улсын Зэвсэгт хүчний шинэчлэлд томоохон түлхэц үзүүлсэн юм.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2019 онд Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр тус улсын Батлан хамгаалахын сайд Коно Таротой уулзалт хэлэлцээ хийлээ. Цэргийн хамтын ажиллагааны үндсэн хоёр чиглэл болох цэргийн инженер, цэргийн эмнэлгийн чиглэлээр хэрэгжүүлж буй "Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг үргэлжлүүлэх, мөн манай улсын Гадаад хэргийн яамнаас тавьсан саналын дагуу Батлан хамгаалах болон Гадаад хэргийн сайд нарын хэмжээний 2+2 зөвлөлдөх уулзалтын шинэ механизмыг бий болгох талаар санал дэвшүүлэв.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 2019 оны 11 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Вьетнамын Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Нго Суан Личтэй албан ёсны хэлэлцээ хийж хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлаар бодит саналуудыг харилцан дэвшүүлж, цаашид талууд зөвлөлдөх уулзалтын механизм бий болгох, мэдээлэл харилцан солилцох, хоёр оронд харилцан цэргийн атташе суулгах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа, цэргийн эмнэлэг, анагаах ухаан, цэргийн сургалт, батлан хамгаалах ач үйлдвэрлэл, цэргийн зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах, цэргийн биеийн тамир, эрдэм шинжилгээ, судалгаа,

найрамдлын төлөөлөгч солилцох зэрэг хамтын ажиллагааны олон чиглэлээр өргөжүүлэхээр харилцан тохиролцсоны зэрэгцээ харилцааны эрх зүйн баримт бичгийн түвшинг ахиулж "Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т хоёр орны Батлан хамгаалахын сайд нар гарын үсэг зурсан нь айлчлалын ач холбогдлыг нэмэгдүүлсэн юм.

ХБНГУ-ын Холбооны батлан хамгаалахын сайд Урсула фон дэр Лайн 2018 онд Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр талууд Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагааны техникийн тохиролцоог шинэчлэн гарын үсэг зурсан нь манай улсын энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх боломж, нөхцөлийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

"Цэргийн салбарын санхүүгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг байгуулсан. Батлан хамгаалахын сайдын БНТУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр БНТУ-ын Үндэсний батлан хамгаалахын сайд Хулуси Акартай албан ёсны хэлэлцээ хийж, Турк Улсаас олгодог цэргийн буцалтгүй тусламжийг сэргээн үргэлжлүүлэх, цэргийн аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллахад түлхүү анхаарах, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр харилцан туршлага солилцох, БНТУ-д Монголын цэргийн алба хаагчдыг үргэлжлүүлэн сургах зэрэг хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны чиглэлийг өргөжүүлэх бодит саналуудыг харилцан дэвшүүлж, цаашид эдгээр арга хэмжээнүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцжээ.

2016 онд Батлан хамгаалахын сайдын Бүгд Найрамдах Итали Улсад хийсэн ажлын айлчлалаар "Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т гарын үсэг зурсан нь хоёр талын батлан хамгаалах салбарын харилцааг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн алхам болсон.

Монгол Улс, Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл хэрэгжив.

АНУ, Монгол Улсын Батлан хамгаалахын сайд нар 2019 онд албан ёсны харилцан айлчлал хийж, АНУ-ын Батлан хамгаалахын сайд Марк Эспер Монгол Улсад албан ёсны айлчлалыг хийв.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболдын 2019 оны 4 дүгээр сард АНУ-д хийсэн албан ёсны айлчлал нь 2011 оноос хойш Монгол Улсын Батлан хамгаалахын сайд айлчилж байгаагаараа өндөр ач холбогдолтой байлаа. Айлчлалын үеэр АНУ-ын Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөх, Элчин сайд ноён Ж.Болтонтой уулзаж, бүс нутгийн аюулгүй байдал, хоёр талын харилцааны асуудлаар санал солилцон Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэхэд үзүүлж байгаа АНУ-ын Засгийн газрын дэмжлэгт талархаж байдгаа илэрхийлсэн. Мөн цаашид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны оролцоогоо нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа илэрхийлэн, нэр бүхий гишүүдээс Конгресст өргөн барихаар бэлтгэж байгаа Гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг батлах үйл ажиллагаанд дэмжлэг хүсэв.

Батлан хамгаалахын сайд Н.Энхболд "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээгч орнуудын Батлан хамгаалахын сайд нарын бага хуралд"-д оролцсон нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээгч орны хувьд чухал ач холбогдолтой арга хэмжээ

болсон бөгөөд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлоход оролцож, Монгол Улсаас энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцооны талаар НҮБ болон гишүүн орнуудын Батлан хамгаалахын удирдах албан тушаалтнуудтай санал солилцож хоёр талын болон энхийг сахиулах ажиллагаа, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцсэн нь чухал ач холбогдолтой байлаа.

АНУ-ын Батлан хамгаалахын сайд Патрик Шанахантай хоёр талын уулзалт хэлэлцээ хийж, хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон. Батлан хамгаалахын сайдын АНУ-д хийсэн айлчлал нь 2018 оны 9 дүгээр сард АНУ-д хийгдсэн Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалаар хоёр орны харилцааны түвшин дээшилж, Өргөтгөсөн иж бүрэн түншлэлд хүрсний дараагаар хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар харилцан ярилцаж, тодорхой зүйлд санал нэгдэж чадсан нь уулзалтын ач холбогдлыг өргөсөн.

"АНУ-ын Агаарын цэргийн хүчин болон Монгол Улсын Зэвсэгт хүчний хооронд байгуулах агаарын цэргийн удирдагчийг бэлтгэх хөтөлбөрийн гэрээ"-г хэлэлцэн тохиролцож гарын үсэг зурсан. Цэргийн алба хаагчид, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх тухай Монгол Улсын Батлан хамгаалах яам, Америкийн Нэгдсэн Улсын Батлан хамгаалах яам хооронд байгуулсан хэлэлцээр"-т хоёр тал гарын үсэг зурж, хэлэлцээрийг баталсан.

2018 оны 6 дугаар сард Сингапур улсад зохион байгуулагдсан 17 дахь удаагийн "Шангри-Ла яриа хэлэлцээ-2018" бага хурлын үеэр Канад улсын Батлан хамгаалахын дэд сайд хатагтай Жоди Томастай хоёр талын уулзалт хийсэн. Уулзалтаар хоёр орны батлан хамгаалах харилцаа, хамтын ажиллагааг энхийг дэмжих ажиллагааны сургалт, харилцан туршлага солилцох чиглэлээр өргөжүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Монгол, Канадын Батлан хамгаалах яамд хоорондын анхдугаар зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 12 дугаар сарын 9-ний өдөр Канад улсад зохион байгуулж Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Х.Батбилэг тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтын үеэр хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойших 46 жилийн хугацаанд хамтын ажиллагаа улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт хурдацтай хөгжиж, нийтлэг үнэт зүйлс, стратегийн хамтын сонирхолд үндэслэсэн "Өргөн хүрээтэй түншлэл"-ийн харилцааг тунхаглан хөгжүүлж буйг дурдаад хоёр орны ард түмний найрсаг харилцааг гүнзгийрүүлэх, бүс нутаг болон дэлхий дахинд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван, тогтвортой байдлыг хангах, Монгол, Канадын батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, урагшуулан эрчимжүүлэх чиглэлээр харилцан санал солилцоо.


Канад улсад Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдыг суралцуулах эрх зүйн үндэс тавигдсанаар анх 2002 онд Канад улсад сургалтад хамруулж эхэлсэн ба 2004 оноос Монгол Улс Канадын Цэргийн сургалт, тусламжийн хөтөлбөрт хамрагдах болсноор суралцах хүний тоо тогтвортой нэмэгдэж ирсэн. Одоогийн байдлаар нийт 220 гаруй цэргийн алба хаагч тус улсын төрөл мөргөлийн сургууль, дамжааг төгсөөд байна.

Цэргийн боловсон хүчнийг бэлтгэх чиглэлээр анхаарч ажилласны үр дүнд жилд дунджаар гадаадын 14 улсад урт ба богино хугацааны сургалт, дамжаанд 300 гаруй цэргийн алба хаагч, АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНТУ, ХБНГУ, Япон, Канад, Австрали зэрэг улсуудын цэргийн академи, их, дээд сургуульд 400 гаруй сонгогч, цэргийн алба хаагч суралцаж мэдлэг, боловсролоо дээшлүүлж байна.

Батлан хамгаалах салбарын



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.К.Шойгу нарыг хүндэт харуул угтан авч байгаа нь. 2018 он



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболдын БНХАУ-д хийсэн ажлын айлчлал. 2019 он



АНУ-ын Батлан хамгаалахын сайд Марк Эспер Монгол Улсын Батлан хамгаалах яамны удирдлагуудтай мэндчилж байгаа нь. 2019 он



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд 3 дугаар сарын Бүгд найрамдах Турк улсад албан ёсны айлчлал хийв. 2019 он



Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд БНСУ-ын Батлан хамгаалахын сайдтай уулзалт хийж байгаа нь



ХБНГУ-ын Холбооны батлан хамгаалахын сайд Урсула фон дэр Лайныг хүлээн авч байгаа нь. 2018 он

хэмжээнд нийт 22 улстай Засгийн газар хоорондын 80 гаруй гэрээ, хэлэлцээр болон яамд хоорондын "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Гадаад арга хэмжээний үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласны үр дүнд гадаад орнуудад цэргийн боловсон хүчнийг үргэлжлүүлэн

бэлтгэх, буцалтгүй тусламж авах, энхийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах, хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг уламжлалт чиглэлээс гадна цэргийн инженер, эмнэлэг, тусгай хүчний болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлд ахиц гараад байгаа юм.

ХИЛИЙН ЧАНАДААС МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ МЭДЭЭЛЖ БАЙНА

ХОЛЫН ЭРГҮҮЛИЙГ ХҮМҮҮНЛЭГИЙН ҮЙЛСТЭЙ ХОСЛУУЛАВ

БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний IX ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүн эх орныхоо нэр хүндийг өндөрт өргөн хүлээсэн үүргээ амжилттай гүйцэтгэсээр байна. Тодруулбал, тус батальон мандатаар заагдсан үүргийн дагуу Хүчний командлагчийн шийдвэр, Юнити секторын командлагчийн

үүрлэсэн, эдгээр амьтдын ялгасны хурц үнэр нэвт шингэсэн, хэрэглээний цэвэр ус, ашиглагдсан бохир усаа зөөвөрлөдөг, амаржих болон мэс заслын өрөөнүүд нь гэрэл, цахилгаангүй учир шөнийн цагт гар чийдэн ашигладаг гээд дурдвал эрүүл мэндийн байгууллага гэж хэлэхэд нэлээд учир дутагдалтай байсан. Монгол цэргүүд тэр бүгдийг бүрэн "халж", засвар, тохижилтын ажлыг амжилттай

чадахгүй өнөөдрийг хүрсэн. Гэтэл монгол цэргүүд сайхан сэтгэл гарган бидэнд тусламжийн гараа сунгаж, ердөө долоо хоногийн дотор эмнэлгийг ус, цахилгаантай болгоод зогсохгүй төрөх өрөө, мэс ажилбарын өрөөг иж бүрэн засварлан тохижуулж өгсөнд маш их талархаж байна" хэмээн онцолсон. Мөн Юнити мужийн зохицуулагч болон Юнити секторын штабын удирдлага ч энэхүү ажлыг өндрөөр үнэлж

асуудлыг шийдээгүй дутуу орхисон. Тэр цагаас хойш тус эмнэлэгт ямар ч засвар, үйлчилгээ хийгдэлгүй өнөөдрийг хүрсэн юм. Өөрөөр хэлбэл, бид 13 жилийн турш гэрэл, цахилгаан, цэвэр бохир усны асуудалтай байж ирсэн. Ер нь иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд маш хүндрэлтэй байсан. Гэвч өнөөдөр монгол цэргүүдийн ачаар энэ асуудлууд бүрэн шийдэгдсэн баяртай байна. Монгол Улсын цэргийн алба хаагчид манай улсад энх тайвныг тогтоохын зэрэгцээ бидний төлөө сайхан сэтгэл гаргаж, хүмүүнлэгийн тусламж, үйлчилгээг ч олон талаар үзүүлж байгаад сэтгэл өндөр байна. Үүний нэг жишээ бол манай эмнэлэгт маш богино хугацаанд засвар, тохижилтын ажлыг хийсэн явдал байлаа. Энэ нь тус районд оршин суудаг 75 мянган хүний эрүүл мэндэд асар их хувь нэмэр оруулж байгаа юм. Тиймээс орон нутгийнхаа нийт иргэдийн нэрийн өмнөөс "МОНБАТТ"-д чин сэтгэлийн талархал илэрхийлж, ажлын улам их амжилтыг хүсье.

эмч нар маань, бас монгол эмч маш сайхан сэтгэл гаргаж ажилласан. Монгол цэргүүд манай улсад ирж НҮБ-ын ажиллагааг явуулж, энх тайван байдлыг тогтоож байгаад, бидний эмнэлгийг шинэчлэн засварласанд, ер нь бидний төлөө хийж байгаа бүхнийх нь төлөө тэдэнд бурхны өмнөөс баярлалаа гэж хэлмээр байна. Энэ бүх ач тусыг нь бодож бид хүүдээ "Монголиа" хэмээх нэр өгсөн. Монгол цэргүүдийн сэтгэл шингэсэн маш цэвэр, тохилог, тав тухтай өрөөнд анхныхаа хүүхдийг төрүүлсэн мөч маань бидэнд хэзээ ч мартагдахгүй гэгээн дурсамж байх болно.

Ийнхүү "MONBATT-IX"-өөр овоглогдсон олон ажил хөрсөнд бууж үйлс зорилго нэгт олон орны дайчдыг манлайлан НҮБ-ын өмнө хүлээсэн үндсэн үүргээ алдаа мадаггүй, нэр төртэй биелүүлж байна. Манай хамт олны хөдөлмөр зүтгэл, хөлс хүчээр бүтсэн олон ажлыг НҮБ-аас үнэлж, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын БНӨСУ дахь НҮБ-ын ажиллагааг хариуцсан тусгай төлөөлөгч ноён Дэйвид Шэарэрээс талархлын захидал ирүүлснийг энд онцлоход таатай байна. Тэр бээр захидалдаа, "Энэхүү завшааныг ашиглан "UNMISS" ажиллагааны мандатад заасан энгийн иргэдийг хамгаалах үүргийг амжилттай хэрэгжүүлэн БНӨСУ-д энх тайвныг бэхжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буй танай цэргийн багийн бүтээлч үйл ажиллагааг баяртай байна. Монгол Улсын IX ээлжийн цэргийн баг 2019 оны 9 дүгээр сард томилогдон ирснээс хойш Юнити мужид үүссэн хэд хэдэн хүндрэлтэй цагийн байдлын үед өөрсдийн мэргэжлийн өндөр ур чадвар, тууштай үнэнч байдал, хичээл зүтгэлээ үйл ажиллагаагаараа харуулсан билээ. Танай цэргийн багаас 2020 оны 1 дүгээр сард Мунга боомтод зохион байгуулсан усны эргүүл, 2020 оны 3, 4 дүгээр сард Маяом болон Абьёмном сууринд цагийн байдлыг тогтворжуулах урт хугацааны эргүүлийн үүргийг энд онцлон дурдахыг хүсье байна. Монгол Улсын цэргийн баг Бентью дахь Дотоодын дүрвэгсдийн хуаран, "Эко" тэргүүний бааз, Жамжанг суурин дахь дүрвэгсдийн хуаранд энгийн иргэд, Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж байгаа талаар "UNMISS"-ийн удирдлагаас удаа дараа бидэнд мэдэгдэж байсан юм. Түүнчлэн орон нутгийн иргэдэд чиглэсэн Иргэн-цэргийн харилцааны болон сайн үйлсийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанууд, тэр дундаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, инженерийн тусалцаа, дэмжлэг үзүүлэх зэрэг Та бүхний зохион байгуулсан олон төрлийн үйл ажиллагаанд талархаж байна. Та бүхний Абьёмном суурин дахь хүн эмнэлгийн байрыг иж бүрэн засварлаж тохижуулсан сэргээн босголтын ажил, мөн НҮБ-тай хамтран коронавирусийн тархалтын эсрэг БНӨСУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн зохион байгуулсан бодитой үйл ажиллагаа, хүчин чармайлтыг бид онцгойлон сайшааж байна. Эцэст нь 2020 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр Бентью суурин дахь Дотоодын дүрвэгсдийн хуарангийн "Зэвсэггүй бүс"-д зэвсэгт этгээдүүд олон улсын хүмүүнлэгийн байгууллагын ажилтныг хүч хэрэглэн хулгайлах гэсэн оролдлыг таслан зогсоосон Монгол Улсын цэргийн багийн зоримог, шийдвэртэй арга хэмжээнд талархлаа илэрхийлж байна. Ажиллагааны мандатад заагдсан үүргээ үнэнчээр биелүүлж буй Монгол Улсын IX ээлжийн цэргийн багийн бүх цэргийн алба хаагчдад дахин талархал илэрхийлж, цаашдынх нь ажил үйлс өндөр амжилт, сайн сайхныг хүсэн өрөөе" хэмээн тодотгосон байна.

СЭТГЭЛ ХӨДӨЛЖ БАЙГААГАА ДАХИН ДАХИН ХЭЛМЭЭР БАЙНА

Эх барих эмч РАЖИНА НЯНЁК:



-Юуны өмнө Монгол Улсын

энхийг сахиулагчдад баярлалаа гэж хэлье. Тэд үнэхээр сайхан сэтгэл гаргаж, манай эмнэлгийг маш сайн засварлан шинэчилж өглөө. Сэтгэл хөдөлж байна. Манай эмнэлгийн нөхцөл байдал маш муу байсан. Бидэн дээр өмнө нь олон улсын хүмүүнлэгийн цөмнгүй байгууллагынхан ирсэн, бид тэр болгоноос тусламж хүсье, эмнэлгийнхээ орчин нөхцөлийг сайжруулах тухай саналаа хэлсэн ч харамсалтай нь тэд шийдэж өгөөгүй. Гэтэл "МОНБАТТ"-ын цэргүүд энэ асуудлыг бүрэн шийдвэрлэж, бидний ая тухтай орчинд ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж өглөө. Сэтгэл хөдөлж байгаагаа дахин дахин хэлмээр байна. Ялангуяа төрөх болон мэс заслын өрөөг тусгайлан засаж тохижуулсанд эх барих эмчийн хувьд туйлын баяртай байна. Төрөх өрөөний хувьд таазнаас нь борооны ус гоождог, халууны улиралд шороо, тоос маш их ордог байсан. Мэдээж тэр бүхнээс хамаарч шинээр төрж байгаа хүүхдүүд халдвар авах магадлал маш их байсан. Одоо бид тэр тухайд санаа зоволтгүй боллоо. Дээр нь гэрэл, цахилгаан, усанд орох шүршүүр, бие засах газар, гар угаалтуур гээд хэрэгтэй бүхнийг маань шийдсэн монгол цэргүүддээ баярлалаа.

БУРХНЫ ӨМНӨӨС ТА БҮХЭНД БАЯРЛАЛАА ГЭЖ ХЭЛЬЕ

Орон нутгийн иргэн АНЖЕЛИНА:



-Орон нутгийн маань эмнэлэг монгол цэргүүдийн ачаар цоо шинэ мэт болсонд, ийм тохь тухтай эмнэлгээр үйлчлүүлж анхныхаа хүүг төрүүлсэндээ маш их баяртай байна. Намайг төрөхөд



захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор Юнити мужийн Абьёмном сууринд урт хугацааны холын эргүүлийн үүргийг 4 дүгээр сарын 20-ны өдрөөс энэ сарын 6-ны өдрүүдэд амжилттай гүйцэтгэлээ.

Эргүүлийн бүлэг энэ хугацаанд зөвхөн эргүүлийн үүрэг гүйцэтгээд зогсохгүй батальоны үүрэг гүйцэтгэлт, хэрэгжүүлж буй аливаа ажил, арга хэмжээнүүдийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа, тэр тусмаа Монгол Улсын мотобуудлагын батальоны талаар орон нутгийн иргэдэд эерэг сэтгэгдэл төрүүлэх зорилгоор дээрх суурины эмнэлэгт засвар, тохижилтын ажлыг өрнүүлсэн юм. Эргүүлийн бүлэг үүрэг гүйцэтгэх үедээ орон нутгийн нэг шархтныг олж хэргийн газраас яаралтай татан гаргалт хийсэн. Түүнийг эмнэлэгт хүргэсэн ба тус батальоны эмч, ахмад А.Ганбат тусламж үзүүлэх үед тус эмнэлэгт эмч байхгүйн дээр эрүүл мэндийн чиглэлээр тусламж, үйлчилгээ явуулах стандарт шаардлагыг хангаагүй, цахилгаан, уснаас эхлээд нэн шаардлагатай зүйлс огт байхгүй, маш хүнд нөхцөлтэй байсан нь засвар, тохижилтын ажлыг өрнүүлэх гол шалтгаан боллоо. Тодотговол, батальоны бүрэлдэхүүн орон нутгийн иргэдэд тусламж үзүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд хийх хамгийн чухал хэрэгцээ, шаардлагатай мөн иргэдэд хүртээмжтэй ажил нь эмнэлгийн засвар, тохижилтын ажил болохыг тодорхойлон шийдвэр гаргаж, 4 дүгээр сарын 26-ны өдрөөс энэ сарын 5-ны өдрүүдэд бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлэв.

Уг эмнэлгийн нөхцөл байдал ямар байсан талаар цухас дурдвал, 13 жилийн турш гэрэл, цахилгаангүй, дээвэр нь хуучирч муудсан, хөндий зайтай, захын хэсгүүдээр дусаал гоождог, өрөөнүүд нь дээврээс тусгаарласан таазгүйгээс шувуу, сарьсан багваахай зэрэг амьтад

гүйцэтгэлээ. Тухайлбал, дээврийг шинэчлэх, хана, таазыг замаскдаж эмүүлдэх, цонх, хаалгануудыг будах, цэвэр, бохир усны сантехникийн холболт (цэвэр ус нөөцлөх зориулалт бүхий 5 тоннын багтаамжтай хоёр савыг цэвэрлэж засвар, ариутгал хийн шугамд холбосон)-ыг хийх, цонхны хөшиг, хаалгануудын хаягийг шинэчлэх зэрэг олон ажлаас гадна гэрэл, цахилгааны асуудлыг бүрэн шийдвэрлэсний зэрэгцээ амаржих болон мэс заслын өрөөг бүрэн засварлан тохижуулсан юм. Мөн тус эмнэлгээр үйлчлүүлэх иргэдийн ая тухтай байдлыг хангах үүднээс эрэгтэй, эмэгтэй бие засах өрөө, шүршүүр, гар угаалтуур, галын аюулгүй байдлыг хангасны дээр цахилгааны хоёр шит, мэс заслын болон амаржих өрөөнд тус бүр нэг аваарын гэрэл суурилуулсан ба эмнэлгийн гадна төв хаалганы дэргэд гар угаах, ариутгах зориулалт бүхий 500 литрийн багтаамжтай цэвэр усны савыг шинээр хийж байрлуулснаас эхлээд эмнэлэгт хэрэгцээ, шаардлагатай бүхнийг бий болголоо. Түүнчлэн 1,5 сая төгрөгийн өртөг бүхий эм, ороох боох материал, эмнэлгийн хэрэгслийг ч хандивлав.

Ийнхүү орон нутгийн эмнэлэгт засвар, тохижилтын ажлыг бүрэн хийж, эмнэлгийг хүлээлгэж өгөх ёслолын ажиллагаа энэ сарын 5-ны өдөр болсон юм. Уг арга хэмжээнд Абьёмном суурины нутгийн захиргааны ахлах төлөөлөгч Макер Куол, Юнити мужийн зохицуулагч хатагтай Хироко Хирахара, Юнити секторын командлагчийн орлогч дарга, хурандаа Имран Сафдор болон эмнэлгийн удирдлага, ажилтнууд оролцов. Нээлтийн үеэр орон нутгийн захиргааны ахлах төлөөлөгч Макер Куол хэлсэн үгэндээ, "Сүүлийн 13 жил манай эмнэлэг гэрэл, цахилгаан мөн усгүй, эмнэлгээр үйлчлүүлэх боломжгүй болоод байсан. Бид үүнийг засварлах саналыг Засгийн газарт удаа дараа уламжилсан ч мөнгө санхүүгийн боломжгүй шалтгаанаар засаж

сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа.

Дашрамд дурдахад, эмнэлгийн засварын ажил явагдаж байх үед тус эмнэлэгт орон нутгийн хоёр иргэн хөлдөө буудуулснаас хүнд шархдаж ирэх үед мотобуудлагын батальоны эмч, ахмад А.Ганбат эмнэлгийн тусламжийг үзүүлж, манай эмчээс зөвлөгөө авч, туршлага судалж байлаа. Тэрчлэн орон нутгийн нэгэн эх амаржих хүү төрүүлсэн юм. Орон нутгийн заншлаар шинээр төрсөн хүүхдэд тухайн эмнэлгээс нэр өгдөг уламжлалтай аж. Энэхүү уламжлалынхаа дагуу эмнэлгийн дарга Саймон Майор Чол, хүүгийн эцэг, эхтэй нь зөвлөлдөж "Монголиа" хэмээн нэр хайрласан нь монголын цэргүүдэд талархсан, монгол эмчийн ур чадвар, сайхан сэтгэлийг үнэлсэн сэтгэлийн илэрхийлэл байсан юм.

Эмнэлгийн засвар, тохижилтын нээлтийн ёслолын үеэр дараах хүмүүсийн сэтгэгдлийг сонссоноо хүргэе.

ДАЛАН ТАВАН МЯНГАН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД АСАР ИХ ХУВЬ НЭМЭР ОРУУЛЛАА

Эмнэлгийн дарга САЙМОН МАЙОР ЧОЛ:



-Манай эмнэлэг 2005 онд баригдаж эхлээд 2007 онд ашиглалтад орсон юм. Гэхдээ барилгын гүйцэтгэгч компани нь зарим хэсгийн тааз болон гэрэл, цахилгаан, сантехникийн



Ахмад Д.МЭНДБАЯР

1941 оны 6 дугаар сарын 22-ны амралтын өдөр фашист герман ул довтолж гэрээгээ итгэл эвдэн зөрчиж, дайн зарлахгүйгээр үлэмж их хүчээр Зөвлөлт улсын эсрэг гэнэт халдан довтолсон билээ. Эх орны дайн эхэлсэн энэ өдөр МАХН-ын Төв хороо, БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлаар Германы зүгээс ийнхүү довтолсныг жигшин эсэргүүцэж 1936 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн хамтран ажиллах, харилцан туслалцах гэрээгээр хүлээсэн үүргээ баримтлан ЗСБНХУ-аас ялан дийлэх явдалд зохих тусламжийг үзүүлэх шийдвэр гаргасан байна. 1941 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод болсон цуглаан дээр Ерөнхий сайд Х.Чойбалсангаас нам, засгаа нягт тойрон хүрээлж, улс орныхоо аж ахуй, батлан хамгаалах хүчийг бэхжүүлэн ЗХУ-ын талд баттай зогсохыг уриалсан юм.

Энэхүү уриалгыг малчин, ажилчин, албан хаагч, оюутнууд зэрэг нийгмийн бүхий л давхаргынхан дуртай хүлээн авч Улаан армид зориулан "Бүхнийг фронтод", "Бүхнийг Улаан армид" хэмээх уриан дор хөрөнгө хуримтлуулах хөдөлгөөнийг өрнүүлсэн байна. Улаан армид бэлэг цуглуулах, түүнийг Зөвлөлт оронд хүргэж өгөх ажлыг зохион байгуулах төв комисс байгуулагдсан ба энэ комиссын бүрэлдэхүүнд Бага хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд, Намын Төв хорооны нарийн бичгийн дарга, Бэлэглэлийн төв комиссын дарга С.Янжмаа, Бүх цэргийн жанжны орлогч, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн, Намын Төв хорооны нарийн бичгийн дарга, Армийн Улс төрийн газрын дарга Ю.Цэдэнбал, Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан нар багтсан байна.

1941 оны 11 дүгээр сард МАХН-ын Төв хорооны бүгд хурал болж Монгол Улсын одоогийн хамгийн чухал бөгөөд үндсэн зорилго нь Зөвлөлтийн ард түмэнд гитлеризмтэй явуулж байгаа тэмцэлд бүхий л аргаар туслах явдал мөн гэж үзсэн байдаг. Учир нь дэлхийн бүх ард түмнийг боолчлохоор аюул занал учруулж байгаа гитлеризмыг ялж дийлэхгүйгээр Монгол Улс цаашид эрх чөлөөтэй, амжилттай хөгжих арга зам байхгүй гэж заасан байна. Аж үйлдвэрийн комбинат, үйлдвэрлэл, хоршооллын ажилчид ням гараг болон ээлжийн амралтын өдрүүдэд илүү цагаар ажиллан 15000 нэхий дээл, эсгий гутал, үстэй бээлий, хантааз, цэрэг бүс, 6000 ширхэг ноосон цамц, 440 нэхий хөнжил зэргийг багтаасан бэлгийн анхны цувааг 1941 оны 11 дүгээр сард илгээсэн байна. Бэлгийн үнэ нь тухайн үеийн ханшаар 587000 төгрөг болж байлаа. Бэлгийн анхны цувааны төлөөлөгчдийг Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч С.Лувсан удирджээ.

Бэлгийн төв ба салбар комиссууд иргэд төв, орон нутгийн төрийн захиргаа, нам, олон нийтийн байгууллагуудаас хөрөнгө хуримтлуулах ажлыг шуурхай зохион байгуулж бэлгийн хөрөнгийг өдрөөс өдөрт арвижуулсаар байжээ. Зөвлөлтийн Улаан армийн 24 жилийн ойг тохиолдуулан 1942 оны 2 дугаар сард бэлгийн хоёр дахь цувааг илгээжээ. Энэ цувааг БНМАУ-ын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч С.Лувсан, Намын Төв хорооны нарийн бичгийн дарга С.Янжмаа, БНМАУ-аас ЗСБНХУ-д сууж байсан Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Самбуу нарын 10-аад хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийн армийн генерал Г.К.Жуковын командалсан Баруун фронтын 49 дүгээр армийн их бууны ба буунийн дивизийн дайчдад гардуулж өгсөн байна. Энэхүү 37 вагон бэлгийн цуваанд 148 тонн мах, 8 тонн хиам, 100 тонн төрөл бүрийн боов, боорцог, 45 тонн тос, 8000 литр архи, 5,5 сая ширхэг папирос тамхи, 2750 хос эсгий гутал, 2706 дах, 4100 дулаан хантааз, 1320 богино нэхий дээл, 6290 хос бээлий, 4500 гэрийн эсгий, 2000 ширхэг суран бүс, савхин гутал, хүзүүний ороолт, чихэр, лаазтай сүү зэрэг зүйлс багтжээ. Бэлэгт зориулж зээр, гахай агнах, сүү тос, мөөг, жимс бэлтгэх ажил эрчимтэй өрнөж байсан ба энэ ажлыг С.Лувсангаар удирдуулсан тусгай комисс байгуулагдан ажиллаж байсан.

1942 оны 1 дүгээр сард болсон БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас "Хувьсгалт Монгол Улс" танкийн бригад байгуулж Улаан армид бэлэглэх шийдвэр гаргасан. Манай Засгийн газраас 2,5 сая төгрөг, 300 килограмм алт, 100 мянган америк долларыг 1942 оны 2 дугаар сард ЗХУ-ын гадаад худалдааны дансанд шилжүүлсэн байна. 1942 оноос эхлэн Улаан армийн цэргүүдийн хэрэгцээнд зориулан иргэдээс агт морь худалдаж авах ажил эхэлжээ. Энэ санаачилгыг дэмжин 1942 оны 3 дугаар сард МАХН-ын Төв хороо, Сайд нарын



ЭХ ОРНЫ ДАЙНЫ ҮЕИЙН БЭЛЭГ ХУРИМТЛУУЛАХ ХӨДӨЛГӨӨН

Зөвлөлөөс улсын үнээр агт морь худалдан авах шийдвэр гаргасны дагуу "Сайн морьд худалдаа" уриан дор чухал компани ажлыг өрнүүлсэн. Зөвхөн 1942 онд малчин ард 104000 морьд худалдаж, 6417 агт бэлэглэсэн. Энэхүү худалдах хөдөлгөөн нь бэлэглэх хөдөлгөөн болж эрчимжсэн байна. Жишээ нь, Завхан аймгийн Их-Уул сумын малчин Гарьд 76, Говь-Алтай аймгийн малчин Ж.Бавуу 55, Ховд аймгийн Дарви сумын малчин Ядам 50, Өмнөговь аймгийн Баяндалай сумын малчин Наваан 43 морио бэлэглэжээ.

1942 он Октябрийн хувьсгалын 25 жилийн ойн жил байсан учир Улаан армид бэлэг илгээх ажлыг богино хугацаанд гүйцэтгэхэд МАХН-ын Төв хороо, Засгийн газар үлэмж анхаарч гурав дахь цувааг мөн оны 11 дүгээр сарын 27-ны өдөр БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангаар ахлуулсан 40-өөд хүнтэй баг "Наушка" өртөөнөөс хөдөлжээ.

Монголын ард түмний чин сэтгэл, цаг наргүй хөдөлмөрөөр бүтсэн бүгд 236 вагон бэлэгт богино нэхий дээл 30115, эсгий гутал 30500, үстэй бээлий 31257, хантааз 31090, цэрэг бүс 33300, ноосон цамц 2290, нэхий хөнжил 2011, дах 3030, эсгий гэр 150, гэрийн эсгий 2428, төрөл бүрийн гутал 2578 хос, эмнэлгийн шаахай 7158 хос, казах эмээл 600, мах 316 тонн, зээрийн мах 26756, тос 92 тонн, хиам 84 тонн, чанамал жимс 12954 килограмм, чихэр 3690 килограмм, печень, гурилан бооны зүйл 70400 килограмм, эдийн саван 50600 килограмм, савхин дээл 150, торгон савхин гутал 150 хос, ажлын гутал 300 хос, цаначны малгай 960, цагаан архи 480 хайрцаг, бичгийн дугтуй 56050, өврийн дэвтэр 27845, нийлээд хамт олны бэлэг 127 авдар, хувийн бэлэг 22176, мөн цаг, хутга зэрэг ард түмний бэлэг бас оржээ. Жишээ нь хошууч Дэмбэрэлийн анги идэвхтэй оролцож бэлэн 713 төгрөг, гурван морь, гурван сарлаг, 14 хонь, ямааг бэлэглэжээ. Байлдагч Пүрэв, Шагдарсүрэн, Молом нар байлдааныг дуусалт сар бүр 8 төгрөгийг бэлэглэхээ илэрхийлжээ. Тэрчлэн эмнэлэгт эмчлүүлж буй байлдагч Цэнд 25 төгрөг бэлэглэсэн аж.

Бэлгийн гурав дахь цуваа нь бусдаасаа томоохонд тооцогдож байсан ба Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн дарга Г.Бумцэнд, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын жанжин Ч.Мижид, МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга Ч.Сүрэнжав нараар ахлуулан дөрвөн хэсэгт хуваагдаж Баруун, Баруун хойд, Волоховын, Калининний фронтуудад бэлгүүдээ гардуулан өгчээ. Энэ үеэр ЗХУ-д үйлдвэрлэсэн Т-34, Т-70 маркийн 53 танкаас бүрдсэн "Хувьсгалт Монгол Улс" танкийн бригадыг 1943 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр Москвагаас холгүй орших танкийн 112 дугаар бригадын бүрэлдэхүүнд маршал Х.Чойбалсан тэргүүтэй төлөөлөгчид хүлээлгэн өгчээ. Танк бүрийн цамхаг дээр оросоор "Хувьсгалт Монгол Улс", дээд захаар нь "МАХН-ын Төв хорооноос", "БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдээс", "БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс", "18 аймгийн ардуудаас", "Аж үйлдвэрийн комбинатын ажилчин, албан хаагчдаас", "Үйлдвэрчин ба

залуучуудаас", "Партизануудаас" гэх зэрэг тусгай нэртэй байжээ. Бэлэг цуглуулах ажил эрчимжиж 1942 оны 12 дугаар сарын 1-нээс 1943 оны 2 дугаар сарын 24-нийг хүртэл гурван сар гаруйн хугацаанд манай ард түмэн 8,3 сая төгрөгийн бэлгийн фонд хуримтлуулжээ.

Бэлгийн дөрөв дэх цувааг 1943 оны 3 дугаар сарын 1-ний өдөр илгээжээ. МАХН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю.Цэдэнбалын ахалсан энэ цуваанд 12000 эсгий гутал, мөн 12000 савхин гутал, 3000 хос ботинк, 500 хос нисгэгчийн гутал, 1000 шаахай, 10000 шинель, 3060 хөвөнтэй өмд, цамц, 1000 морин цэргийн эмээл, 10500 цэрэг бүс, 38 эсгий гэр, 628 унадаг дугуй, төрөл бүрийн хувцас, сахлын анхаарч гурав дахь цувааг мөн оны 11 дүгээр сарын 27-ны өдөр БНМАУ-ын Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсангаар ахлуулсан 40-өөд хүнтэй баг "Наушка" өртөөнөөс хөдөлжээ.

Энэ тухай 21 дүгээр армийн командлагч, гвардын дэслэгч генерал Чистяков, Цэргийн зөвлөлийн гишүүн, хошууч генерал Крайнов, Улс төрийн хэлтсийн дарга, хураандаа Соколов нараас Монгол Улсын төрийн удирдагч нарт ирүүлсэн цахилгаан утсандээ МАХЦ-ийн командлагч Ж.Лхагвасүрэн тэргүүтэй мянгат малчин Пунцаг, партизан Наваан, ударник эмэгтэй Нямсүрэн нарын зочид 21 дүгээр армид бэлэг гардуулсанд баяр хүргэжээ.

1943 оны 3 дугаар сард хуралдсан БНМАУ-ын 26 дугаар бага хурлаас "Монгол ард" нисэх онгоцны эскадрилийг байгуулах шийдвэр гаргажээ. 1943 оны 8 дугаар сарын 18-ны өдөр И.В.Сталинаас Ерөнхий сайд, маршал Х.Чойбалсанд ирүүлсэн цахилгаан утсандээ "ЗХУ-ын Засгийн газар, Улаан цэрэгт зориулан "Монгол ард" нисэх онгоцны эскадриль байгуулахаар 2 сая төгрөг цуглуулж бэлэг болгосонд Танд ба танаар уламжлан БНМАУ-ын Засгийн газар, ард түмэнд үнэн зүрхний талархал илэрхийлье" гэжээ. МАХН-ын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Армийн Улс төрийн газрын дарга Ю.Цэдэнбал, БНМАУ-ын Цэргийн явдлын яамны сайд Ж.Лхагвасүрэн нарын ахалж явсан энэ цувааны төлөөлөгчид Зөвлөлтийн дарга, цэргүүдтэй уулзаж Монголын ард түмний илгээсэн бэлгийг гардуулан өгч, ялалт түргэн ирэх болтугай гэсэн ерөөлийн үгийг дэвшүүлж байжээ.

Монголын төлөөлөгчдийг Зөвлөлтийн 61 дүгээр армийн командлагч баяртай хүлээн авч баяр хүргэхийн зэрэгцээгээр тийрэлтэт артиллерийн батареины байлдааны суман дээр үг бичихийг Ю.Цэдэнбал даргаас хүсэхэд тэрээр "смерть" буюу "ухэл" гэж бичжээ. 1939 онд Халхын голын байлдаанд Монгол-Зөвлөлтийн цэрэг Японы милитаристуудтай байлдаж байх үед энэхүү дайны үеийн Монгол-Зөвлөлтийн цэргийг мал,

мах, хүнс тэжээл, мөнгө санхүүгээр хангах Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчөөр Ю.Цэдэнбал дарга томилогдон Монголын өмнө ба зүүн талын аймаг, сумдаар явж даалгасан төр, засгийн даалгаврыг цагт нь гүйцэтгэсэн. Энэ үед Г.К.Жуков, Ю.Цэдэнбалтай уулзахдаа "Чиний бэлэг болгосон үхэр, хонины мах тарган байлаа" гэж талархжээ.

Ю.Цэдэнбал бэлгийн дөрөв дэх цувааг ахалж Зөвлөлтийн фронтод бэлэг хүргэх явцада Г.К.Жуковтой уулзаж түүнд тусад нь зэхсэн монгол дээлийг бэлэглэхэд Г.К.Жуков баяртай хүлээн аваад "Энэхүү дээлийг би фронтод авч явж галт тэргэнд өмсөнө" гэсэн аж.

Монголын ард түмний хөрөнгөөр байгуулагдсан "Ла-5" маркийн 12 нисэх онгоцноос бүрдсэн "Монгол ард" нисэх онгоцны эскадрилийг дэслэгч генерал А.Е.Благовещенскийн нэгтгэлд 1943 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр гардуулсан ба энэ эскадриль нь Беларусь Литва, Дорнод Прусс, Польш, Герман, Чехословакийн нутгийг чөлөөлөхөд оролцсоноор Монголын ард түмний хүслийг биелүүлжээ. Энэ эскадриль нь гарамгай гавьяа байгуулсан учир ЗХУ-ын Байлдааны улаан тугийн одон болон Суворовын одонгоор шагнагдаж, 1944 оны 7 дугаар сард Оршийн нэрэмжит болжээ.

1945 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр болсон эскадрилийн дайчдын нэгдсэн хурлаас маршал Х.Чойбалсанд ирүүлсэн захидалд 1944 онд "Монгол ард" эскадриль нь 547 байлдааны нислэг хийж, агаарт 38 онгоц сөнөөж, газар дээрх дайралтын явцад хоёр гүүр дэлбэлж, 70 авто машин, галт тэрэгний хоёр цувааг устгасан. Мөн дайсны аэродром дээрх "Ю-88" маркийн тав, "ХБ-111" маркийн гурван онгоцыг тус тус устгасныг илтгэжээ.

Дөрвөн удаагийн бэлгийн цуваагаар Монголын ард түмний илгээсэн бэлгийн үнэ бэлэн мөнгөөр 24.894.311, ард шир, түүхий эд, ноос, ангийн ус, дулаан хувцас зэргийн үнэ 458957 төгрөг болжээ. Цугласан алт, мөнгийг тухайн үеийн ханшаар үнэлж бодвол 522607 төгрөг, фронтод удаа дараагаар явуулсан гарын бэлэг 5982, төрөл бүрийн зүйлүүдийн үнэ 661565, бэлтгэж явуулсан зэрлэг гахай, зээр, шувууны үнэ 558955 гээд бүгд 28,193,053 төгрөг болжээ. Эхний гурван удаагийн бэлгийн цуваанд бод мал 25301, бог мал 254450-ыг шилжүүлжээ.

Тав дахь удаагийн бэлгийн цувааг БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч Б.Ламжав, Н.Жагварал нарын төлөөлөгчид 1944 оны 1 дүгээр сард Украины 1 дүгээр фронтод хүргэжээ. Энэ цуваанд эсгий гутал 31000, янз бүрийн савхин гутал 1600 хос, цэрэг нэхий дээл 20,000, шинель 2000, ямаан дах 1010, суран бүс 2200, үстэй хөнжил 870, эмнэлгийн шаахай 3000, хүзүүний ороолт 2000, ноосон бээлий 2486, гэр 6, эсгий 5408 метр, эдийн саван, махор тамхи 83 гаруй тонн, малын ба гахайн мах 158 тонн, хиам, шар тос, чанасан жимс бүгд 80 тонн, зээр 14424, шувууны мах 2364, сүлжмэл зүйл ширхгээр ба хосоор 4920 зэрэг нийт 36 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, хувийн бэлэг 12460 багтсан 127 вагоноос бүрдсэн байна. Цувааны 102 вагоныг "Наушка" өртөөнөөс, 25 вагоныг "Чойбалсан" станцаас илгээсэн ба нийт үнэ нь 8 сая төгрөг болжээ.

Улаан цэрэгт ба чөлөөлөгдсөн бүс нутгуудын ард түмэнд зориулан хөрөнгө хуримтлуулах хөдөлгөөнийг Улаанбаатар хот /2,558,296 төгрөг/ Увс аймаг /517,877 төгрөг/, Архангай аймаг /509,334 төгрөг/ тэргүүлж, гар үйлдвэрийн хоршоолол, засан хүмүүжүүлэх, Аж үйлдвэрийн комбинат, хиамны үйлдвэр, савангийн завод, хотын худалдааны трест зэрэг газрууд онцгой сайн оролцжээ.

6 дугаар цуваа 1945 оны 1 дүгээр сард фронтод хүрчээ. Түүнд олон арван мянган дулаан хувцас, хэрэглэл, олон зуун мянган тонн хүнсний зүйл оржээ. Цувааг МАХН-ын Төв хорооны нарийн бичгийн дарга С.Янжмаа Украины 1 дүгээр фронтын төлөөлөгчийг Москва хотноо ирүүлж хүлээлгэн өгчээ.

Монголын ард түмнээс илгээсэн удаа дараагийн бэлгийн цуваа нь Германы цэргийн цахилгааны дайны төлөвлөгөөг сүйрүүлсэн Москвагийн дэргэдэх ялалт, дайны явцад үндсэн эргэлт гаргасан Сталинградын,

Зөвлөлтийн нутгаас дайсныг үлдэн хөөж, бүх фронтоор давших эхлэлийг тавьсан Курскийн тулалдаан, Дорнод Европын орнуудыг чөлөөлж фашист германыг бут цохисон 1944-1945 оны чөлөөлөхө байлдаан зэрэг чухал ялалтуудад, янз бүрийн фронтод хүрч очиж байснаараа онцлог юм.

Бэлэг гардуулахаар очсон Монголын ард түмний төлөөлөгчдийг улсын хил давсан цагаас Зөвлөлтийн зам зуурын хотуудын удирдлага тосон уулзаж, Зөвлөлт үер, Улаан армийн командлагч хийгээд фронтын шугаман дээр байлдаж байсан Зөвлөлтийн анги, нэгтгэлийн дайчид, дарга нар халуун дотноор хүлээн авч, өөрсдийн ялалт амжилтаас танилцуулж, уулзалт зохион байгуулж байлаа. Тэрчлэн олзлогдсон герман цэргүүдтэй манай төлөөлөгчдийг уулзуулж, чөлөөлөгдсөн хот, тосгонуудтай танилцуулж байлаа.

Монголын ард түмний чин сэтгэлийн бас нэг илэрхийлэл нь фронтын дайчдад захидал илгээх хөдөлгөөн байлаа. МАХН-ын Төв хорооны дэргэд "Фронтод харилцах тусгай тасаг" ажиллаж ялалтыг хүссэн хэдэн зуун мянган захидлыг тасралтгүй илгээж байсны тоонд БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас 95 хүний гарын үсэг бүхий шүлэглэсэн илэрхийлэлт, 1942 оны намар Улаанбаатар хотын хөдөлмөрчдийн нэрийн өмнөөс 800 хүний гарын үсэгтэй захидал зүй өсоор орно. монголоос очсон захидлын хариу фронтоос мөн мянга, мянгаар ирж, Улаан армийн дайчдын ялалтын баяр, талархал, тэдний ялалт амжилтын мэдээг авчирдаг байлаа. Монгол, Зөвлөлтийн дайчдын мянга мянган захидлын багагүй хэсгээр бүрдсэн "Монголоос фронтод", "Фронтоос Монголд" гэдэг захидлын цоморлог нэртэйгээр хэвлэн гаргасан нь олон түмний урмыг сэргээсэн, ухуулга сурталчилгааны бас нэг хэлбэр болжээ.

Ийнхүү дайны фронтоос 6700 километр алслагдсан гүн ар талд монголчууд бүхий л бололцоогоо дайчлан хөдөлмөрлөж, Улаан армид туслах олон хэлбэрийн ажлыг өрнүүлсний дүнд нийтдээ 435 сая төгрөгийн үнэ бүхий мал, эд материалын зүйл ба 300 килограмм алтыг биетээр өгч 485000 морьд худалдаж, 32500 гаруй шилдэг хүлгийг фронтод илгээжээ.

Монголын ард түмний энэхүү тусламжийг Зөвлөлтийн дайчид өөрсдийн ялалтаар харуулж, Зөвлөлт Холбоот Улс өндрөөр үнэлж байв.

ЗСБНХУ-ын Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1944 оны 7 дугаар сарын 11-ний өдрийн зарлигаар Германы зээрхэг түрэмгий нар луу байлдаж буй Улаан армид БНМАУ-аас туслах хэрэгт гарамгай гавьяа байгуулсан БНМАУ-ын маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал болон Г.Бумцэнд нарыг Лениний одонгоор, Ч.Сүрэнжав, С.Янжмаа, Д.Дамба, С.Лувсан нарыг Хөдөлмөрийн улаан тугийн одонгоор, Ж.Чойдог, Б.Тогмид, Ж.Аюурзана нарыг Улаан одон, тэмдгээр шагнасан бол Улаан армийн Ерөнхий командлагч Г.К.Жуковоос 1945 оны 5 дугаар сарын 2-ны өдөр ирүүлсэн цахилгаан утсандээ "Энэхүү аймшигт, хатуу ширүүн тэмцэлд танай ард түмний үзүүлсэн тусламжийг ямагт үнэлж, мэдэрч байна" гэжээ.

Энэ ялалтыг авчрахад үнэлж баршгүй гавьяа байгуулсан нам, улс, олон нийтийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн байгууллагуудын удирдагч ажилтан, иргэд хөдөлмөрчид нийт 521 хүнийг төрийн дээд одон, медалиар шагнажээ.

Монгол Улсын Гавьяат багш, дэд профессор Ц.ТӨВӨӨ

"НЯСУУН" УНДААГ ХОББИ БОЛГОСОН



"Хобби" булан маань уншигчдад хүрсэн цагаасаа нүд бүлтгийлгэж, чих дэлдгийлгэм сонин, содон гэмээр цуглуулгатай олон ч эрхмийг онцолсон. Энэ л жишгээр А.Эрхэмбаярын хэмээх олон хүүхэд шуугилдсан нэгэн айлд өнжлөө.

Та гаднын орнуудаар эсвэл аль нэгэн дэлгүүрээр зочлохдоо гоёмсог хэлбэр, хийцтэй агаад гарын атганд ч багтах хэмжээтэй жижигхэн архи, виски, виног анзаарч байсан уу? Тэгвэл тэр бүхнийг зүгээр л анзаараад өнгөрөлгүй хорхойсож, цуглуулга болгосон хүн бол А.Эрхэмбаяр юм. Түүний цуглуулгыг согтууруулах ундаа бус бэлэг, дурсгалын шинж чанартай зүйлс гэдэг талаас нь хүлээж авсан юм. Гэрийн хоймор хэсэгт байх шилэн хаалгатай том модон шүүгээнд өрсөн эдгээр чамин шил, боодол, лонхтой "хатуу" чанарын ундаанууд цуглуулгынх нь нэгээхэн хэсэг нь аж. Учир нь өдий хэмжээний цуглуулга хайрцгаанд хав дарагджээ. Ер нь ч цуглуулгын тоо ихсэхийн хэрээр багтаах зай, завсар олдохоо байдаг нь "Хоббитон"-уудад маань тохиолддог нийтлэг бэрхшээл аж. А.Эрхэмбаяр ч хав дарсан цуглуулгаасаа танилцуулна гээд гав шав хийж

л насаараа спиртийн төрлийн зүйлээс харшилтай мэт холоур дөлж явсан нь цуглуулгын тоогоо 1000 дөхүүлж, бүгдийг нь лацтай чигээр нь салхи оруулалгүй хадгалахад нөлөөлсөн юм уу даа гэсэн бодол өөрийн эрхгүй төрж байв. Тэрээр залуус, дүү нартаа битгий уу гэж хэлэхгүй ч сархад гэгчийг тааруулж хүртэж байгаарай гээд үргэлжлүүлэн цэргийн холбогдолтой чамин цуглуулгаасаа сая нэг "сарвайхад" ёстой л загатнасан газар маажих шийг болов. Эхлээд дундад зууны үеийн цахиур буу, "АК" загварын буу, мина зэргийг гаргаж үзүүлээ. Доторхыг нь харахгүй бол мина нь жинхэнэ гэж ойлгогдохоор ажээ.

Болор шилийг хүртэл гоёлын "Revolver" гар бууны хэлбэрт оруулсан Tequila ч байх юм. Энэ бол А.Эрхэмбаярт их "тоогдож" араас нь нэхэн нэхэн явсан ч олдоогүй удсан эд. Харин нэг л өдөр өөрөө гэрт нь "гүйх" шахам ороод ирсэн гэнэ. Эрэл сурал болсон энэ "гайхал" бэлэг болоод өөрийнх нь мэдэлд ирэхээр бага зэрэг гайхсан ч санасандаа хүрсэндээ ихэд олзуурхжээ. Зөвхөн өөрийн эрэл хайгуулаар 1000 гаруй цуглуулгатай болсон гэвэл өрөөсгөл юм. Танилын хүрээ, ойр дотнынхон нь түүний "эрдэнэсийн сан"-г нь баяжуулсаар өдий зэрэгтээ хүргэсэн гэвэл үнэнд

зураасандаа баригдсан ч хэвийн ажилладаг. Гэр бүлийнх нь хүний хувьд, сүрчиг цуглуулдаг бөгөөд нийт цуглуулгын тоо мөн л 20 хүрээд байгаа аж. Би ч гэр бүлийн бусад гишүүдийг цуглуулгаа гурван оронтой тоонд хүргэхээр нь эргэн уулзахын өрөөл тавиад хөл хөөрцөг боллоо. А.Эрхэмбаяр бүх цуглуулгаа хаанаас, хэзээ, ямар үнээр авсан гээд түүхийг нь 10 хуруу шигээ нэвтэрхий мэддэг юм байна. Бид зах зухаас нь л онцолж, уншигч танд болгоож байна. Бүгдийнх нь талаар бичнэ гэвэл сонины зай, талбай багадаа таарна. Чухамдаа л цуглуулгынхаа өлөн тоосыг арчиж, байсан байранд нь буцаагаад өрөхөд нэг хоног ч багадаа гэнэ.

А.Эрхэмбаяртай манай Зэвсэгт хүчинд ч өвөрмөц хоббитой хүмүүс байдаг талаар ярьж сэдэв хазайгаад авсан. Тэдний нэг нь Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ аж. Мэдээж энэ талаар нэхэн сурвалжилж ямар хоббигоор өвчилсөн хүн бэ гэдэг асуултын хариур энэ салбарт ч их элэгтэй хүн шиг санагдсан. Санасан ажил бүтлээ хэмээн биднийг буцах гэтэл хананд өлгөөстэй мөнгөн тэмдэгтийн цуглуулгууд уяж орхив. Ингээд А.Эрхэмбаярыг хэсэг зуур "шалгаах боллоо". Ардын хувьсгалаас өнөөдрийг хүртэлх он жилүүдэд хувирч гандсан бас шинэ хэвлэлтээс гарсан болон тэмдэглэлт ойн баяруудаар үйлдвэрлэгдсэн зоосон мөнгөнүүд ч бий аж. Хожим ийм хоббитой болсон гэх авч хүүхэд байхдаа зоосон мөнгө цуглуулж эхэлсэн байна. Түүнд төрөл бүрийн цуглуулгууд бий. Зарим нь бүр "Swarowski" шигтгээтэй гоёлын зоос ч байх аж. Мөн 1937 онд Герман улсад үйлдвэрлэгдсэн зоосон мөнгө ч байна. Германы таван маркийн мөнгөн зоос аж. Нүүрэн талдаа хоёрдугаар Рейхийн хөрөгтэй. Эсрэг талдаа Гитлерийн Нацистын бэлгэдэл хас тэмдэг, бүргэдтэй. Яг ийм зоосыг хэд хоногийн өмнө UNE-



гарлаа. Энэ хооронд өнөөх өндөр шүүгээний хамгийн дээр заларсан хүний гавал хэлбэртэй лонхнууд улаан, шар, цэнхэр өнгөөр солонгорон гэрэлтэх нь нүдэнд торлоо шүү. Хажууханд нь хуучны "Форд" машиныг дуурайлгасан нь ч байх юм. Багадаа "Амьдралын нахиа" гэдэг киног үзчихээд архи гэж зүйлийг хэрхэн жигшсэн талаараа Б.Эрхэмбаяр аавдаа ярьж байсан тухайгаа энэ зуур хуучлаад амжсан. Бүхий



нийцнэ. Тухайлбал, түүний эхнэр нь анхдагч гэх тодотголтой цуглуулгыг нь түүчээлж зарим сонирхолтой дурсгалын зүйлсийг ч авчирсан. "Алтын дэргэдэх гууль шарлана" гэдэг шиг авынхаа үлгэрлэлийг хүү нь өвлөж байгаа тухай яриа ч бидний дунд өрнөсөн. Эднийх хоёр охин, нэг хүүтэй. Хүү нь утас цуглуулдаг хоббитой. Samsung Galaxy S1, Iphone 4 зэрэг 20 гаруй утас байдаг аж. Зарим нь хуучирч сэв

GUI.MN дээрээс нэг сая төгрөгөөр үнэлсэн байхыг олж харснаа гэнэт санах. Ер нь тэгээд цуглуулга гэдэг цаг хугацаа өнгөрөх тусам үнэ цэн нь улам өсдөг жамтай. Харин цуглуулгаа арвижуулах гэж хүн өмнөхөөсөө илүү их хөдөлмөрлөдөг, бүтээлч чанарт суралцдаг гэдгийг А.Эрхэмбаяр сонирхол нэгтгүүддээ манай сониноор дамжуулан уламжилсан юм.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

ЭМГЭНЭЛ

ГЭНДЭНГИЙН ТӨМӨР (1929-2020)



Ахмад дайчин, чөлөөнд байсан хурандаа Гэндэнгийн Төмөр нь 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр өвчний улмаас таалал төгсөж үр хүүхэд, ахан дүүс, анд нөхдөд нь хүнд гарз, нөхөж баршгүй уй гашуу тохиолоо.

Тэр бээр хорин настайдаа буюу 1949 онд цэрэгт татагдан ирж Цэргийн Ерөнхий Сургуульд суралцсан ба дэслэгч цолтой төгссөнөөс хойш Ардын Армид 33 жил тасралтгүй ажиллахаа Батлан хамгаалах яам болон Ардын Армийн 17 анги, салбаруудад суман, ротын улс төрийн орлогч, ангийн ухуулах ажлын зааварлагч, улс төрийн орлогч, Барилгын хорооны намын комиссын дарга зэрэг албыг нэр төртэйгөөр гүйцэтгэж ирсэн тэргүүний офицер байлаа.

Г.Төмөрийн хөдөлмөр, зүтгэлийг төр, засгаас өндөрөөр үнэлж Сүхбаатарын одон, Цэргийн гавьяаны улаан тугийн одон, Цэргийн гавьяаны одон, "Алтан гадас" одон болон бусад медалиуд хүртээсэн юм.

Түүний гэр бүл, үр хүүхдийнхээ төлөө байнгын анхаарал, халамж хандуулж ирсэн хүнлэг, эгэл даруу, ажилч хичээнгүй зан чанар, гэгээн дүр төрх нь бидний зүрх сэтгэлд үүрд хоногшин үлдэх бөгөөд бид ямагт дурсаж явах болно.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ БОЛОН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН АХМАДЫН ХОРОО, ҮР ХҮҮХДҮҮД, АХ, ДҮҮ, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД НЬ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг "Соёмбо" сонин
редакцад бэлтгэж,
"Соёмбо принтинг" хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

АУГАА ИХ ЭХ ОРНЫ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД


ХӨШӨӨ ДУРСГАЛУУД

"Хувьсгалт Монгол Улс" танкийн цувааны дурсгалын "Т-34" танкийн хөшөөг 1968 онд танкийн цувааг нийлүүлсний 25 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотын Ажилчны районы 19 дүгээр хорооллын замын тойрог (одоогийн тэмээн жингийн хөшөө байгаа газар)-т анх байгуулжээ. Хожим



"Хувьсгалт Монгол Улс" танкийн хөшөө

уг танкийн хөшөөг Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолборт шилжүүлэн байрлуулсан юм.



"Монгол ард" эскадрилийн хөшөө

"Монгол Ард" нисэх эскадрилийн дурсгалын дээш цойлон нисэж буй гурван "Ла-5" (Лавочкин) онгоцны дүрс бүхий хөшөөг 1985 онд Аугаа Эх орны дайны ялалтын 40 жилийн ойгоор Улаанбаатар хотын Найрамдлын районы Офицеруудын ордны замын тойрог тус тус байгуулжээ.

Эдгээр хөшөөнд Аугаа Эх орны дайны ялалтын болон "Хувьсгалт Монгол Улс" танкийн цуваа, "Монгол ард" эскадриль байгуулагдсаны ойг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, ахмад дайчдын байгууллагаас цэцэг өргөж хүндэтгэл үзүүлдэг.

БНМАУ-аас дайны хүнд үед ЗХУ-д тусламж үзүүлж байсны дурсгал болгож уран барималч А.Очирболдын бүтээсэн 11 метр урт, 2 метр өргөн, 2,3 метр өндөр их буу чирч яваа хоёр



Москва хотын Хүндэтгэлийн уулан дахь Ялалтын цэцэрлэгт хүрээлэнд босгосон "Ялалтад тэмүүлсэн морьд" хөшөө

монгол морины дүрс бүхий "Ялалтад тэмүүлсэн морьд" ("По дорогам войны") хэмээх хүрэл хөшөөг Аугаа Эх орны дайны ялалтын 70 жилийн ойгоор Монгол Улсаас ОХУ-д бэлэглэсэн. Энэ хөшөө одоо Москва дахь Аугаа Эх орны дайны ялалтын дурсгалын аварга цогцолбор сүндэрлэсэн Хүндэтгэлийн уул (Поклонная гора) хэмээх соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнд хүндэтгэлтэйгээр заараад байна. Хөшөөний боржин чулуун суурин дээр "Монголын ард түмэн, Аугаа Эх орны дайны эхний өдрөөс Зөвлөлтийн ард түмний үнэнч Холбоотон байж, танкийн цуваа, нисэх онгоцны эскадриль, хагас сая гаруй агт морьд, дулаан хувцас, хүнс бүхий бэлгийн цувааг фронтод илгээн Их Ялалтад хувь нэмрээ оруулжээ" гэж монгол, орос хэлээр алтан үсгээр сийлсэн байна.

Монгол, Оросын дайчин нөхөрлөлийн бэлгэдэл болсон энэхүү хос морьт хөшөө Москвад очсон монгол хүн болон Монгол, Оросын уламжлалт найрсаг харилцаа, дайчин нөхөрлөлийг мэддэг, хүндэтгэдэг хүн бүрийн сэтгэлд ойр дотно дурсгалт газар болсон билээ.

ЯЛАЛТЫН ОЙН ЁСЛОЛЫН ЖАГСААЛД МОНГОЛ ЦЭРГҮҮД ...

Монгол Улс 1939 оны Халхын голын байлдаанд Монгол, Зөвлөлтийн цэргийн байгуулсан хамтын ялалтын 75 жилийн ойг 2014 онд, 80 жилийн ойг 2019 онд тэмдэглэв. Эдгээр ойн арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн урилгаар Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин хоёр удаа ирж оролцохдоо Халхын голын байлдаанд оролцсон ахмад дайчдад биеллэн хүндэтгэл үзүүлсний дээр Аугаа Эх орны дайны үед ЗХУ, түүний Улаан армид боломж, чадлын хэрээр тусалсан Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөллийг Аугаа Эх орны дайны ялалтын 70, 75 жилийн ойн цэргийн ёслолын жагсаалд оролцохыг урьсан.

Энэхүү урилгын дагуу Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний төлөөлөл 2015 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Москвад болсон цэргийн ёслолын жагсаалд оролцов. Ёслолын жагсаалд сонгон



шалгаруулалтаар тэнцсэн Зэвсэгт хүчний 63, Хилийн цэргийн 12, бүгд 75 цэргийн алба хаагчаас бүрдсэн бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний Төрийн хүндэт харуулын 032 дугаар ангийн захирагч, хурандаа Л.Батболдын командан дор Улаан талбайд Монгол Улсын Төрийн далбаагаа мандуулан алхсан билээ. Ялалтын 70 жилийн ойн ёслолын ажиллагаанд Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин хэлсэн үгэндээ, Монгол Улс Эх орны дайны эхний өдрөөс ЗХУ-ын үнэнч холбоотон байж Зөвлөлтийн Улаан армид туслан их ялалтад хувь нэмрээ оруулсныг тэмдэглэсэн.

Аугаа Эх орны дайны ялалтын 70 жилийн ойд Монгол Улсын Төрийн тэргүүнийг урьж Улаан талбайн цэргийн ёслолын сүрт жагсаалд Монголын цэргийн бие бүрэлдэхүүний төлөөллийг оролцуулсан нь Эх орны дайны үед манай ард түмний үзүүлсэн тусламжийг дурсан хүндэтгэсэн, ОХУ, Монгол Улс, хоёр ард түмний найрамдалт харилцаа, дайчин нөхөрлөлийг илэрхийлсэн чухал ач холбогдолтой үйл явдал байлаа.

Бэлтгэл хурандаа Г.ЛҮНДЭН

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Mil_newssoyombo@yahoo.com
Утас: 70001029